# ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ЭРХЛЭХ АСУУДЛААР ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТИЙН ЯВЦАД 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2018 оны 01 дүгээр сарын 18

## **Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд салбарын асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тухайн жилд тавьсан зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

## **Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй**.

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд яамны эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн 2017 оны жилийн эцсийн тайлан, Ашигт малтмал, газрын тосны газраас гаргадаг статистик мэдээллийн эмхтгэл болон бодлогын газруудын үйл ажиллагааны төлөвлөгөөний жилийн эцсийн биелэлтэд үндэслэн гүйцэтгэв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн тухайн онд хэрэгжүүлсэн ажлын бодит үр дүнг мөн оны хүрэх түвшинтэй харьцуулан биелэлтийг хувиар тодорхойлж үнэлгээг гаргав.

## **Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**.

Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан 36 зорилтын 105 арга хэмжээ, үүнээс 76 арга хэмжээг толгойлон, 28 арга хэмжээг хамтран, 1 арга хэмжээг оролцогчоор хэрэгжүүлэхээр тусгагдсаныг хяналтанд авч сайдын 2017 оны А/22 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг хангаан ажиллаж байна.

Жилийн эцсийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний unelgee.gov.mn цахим системд байршуулсан 28 зорилтын 85 арга хэмжээний хүрээнд хийлээ.

Биелэлт гаргаж ирүүлсэн 85 арга хэмжээнээс 65 арга хэмжээг яам толгойлон, 20 арга хэмжээг бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлжээ.

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилтоор нь авч үзвэл Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлогын хүрээний 1 зорилтын 3 арга хэмжээний биелэлт 60.0 хувь, Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлогын хүрээний 22 зорилтын 73 арга хэмжээний биелэлт 69,5 хувь, Нийгмийн бодлогын хүрээний 1 зорилтын 1 арга хэмжээний биелэлтэд үнэлгээ өгөөгүй, Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогын 4 зорилтын 8 арга хэмжээний биелэлт 60,0 хувь, хэрэгжүүлсэн нийт 85 арга хэмжээний биелэлтийг 68,4 хувьтай дүгнэлээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЯВЦЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО

/2017 оны жилийн эцэс/

| **Зорилт** | **Зорилтын тоо** | **Арга хэмжээний тоо** | **Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо** | | | | | **Хэрэгжилт /хувь/** |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 70 | 40 | 0 | /-/ | |
| Нэг. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого | 1 | 3 | | 2 | 1 | | | 60,0 |
| Хоёр. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого | 22 | 73 | 19 | 27 | 20 | | 7 | 69,5 |
| Гурав. Нийгмийн бодлого | 1 | 1 | | | | | 1 | /-/ |
| Дөрөв. Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого | 4 | 8 | | 4 | 2 | | 2 | 60,0 |
| **Дүн** | **28** | **85** | **19** | **33** | **23** | | **10** | **68,4** |

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний биелэлтийг хэрэгжүүлэх он тус бүрээр үзүүлэв.

| **Хэрэгжүүлэх он** | **Арга хэмжээний тоо** | **Хэрэгжилтийн дундаж, %** | |
|---|---|---|---|
| | | **2017 хагас жил** | **2017 жилийн эцэс** |
| 2017 | 13 | 64,0 | 65,0 |
| 2016-2017 | 15 | 76,9 | 87,1 |
| 2016-2018 | 2 | 40,0 | 40,0 |
| 2016-2019 | 5 | 40,0 | 52,0 |
| 2016-2020 | 29 | 54,3 | 68,8 |
| 2017-2018 | 7 | 52,8 | 70,0 |
| 2017-2020 | 14 | 33,0 | 56,3 |

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан дараах арга хэмжээний биелэлтэд 100 хувийн үнэлгээг өгөв. Үүнд:

- *2.48.6. “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийг боловсруулан батлуулах*
- *2.61.4. Эдийн засгийн үр ашигтай төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх*
- *2.62.1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хялбаршуулах талаар судалгаа хийж, хэрэглэгчдэд ойлгомжтой байдлаар тусгай зөвшөөрөл олгох, мэдээллийг ил тод, нээлттэй түгээх аргачлалын санал боловсруулах*
- *2.63.4. Газрын тосны ордын ашиглалтыг эрчимжүүлж, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх*
- *2.63.7. Газрын тосны борлуулалттай холбогдсон гэрээ, хэлцлүүдийг хийж, үнэ болон худалдааны таатай нөхцөлийг бүрдүүлэх*
- *2.64.1. “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг шинэчлэн боловсруулах,*
- *2.67.1. Тухайн үйлдвэрийн технологиор ашиглах боломжгүй овоолго, хаягдлын аж ахуйг эргүүлэн ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх,*
- *2.68.1. Алт-2” хөтөлбөрийн санхүүжилтийн тооцоог гаргах*
- *2.68.2. Санхүүжилтийн тооцоог Монгол банкинд хүргүүлж шийдвэрлүүлэх*
- *2.69.1. "Алт-2” хөтөлбөрийг боловсруулан батлуулах,*
- *2.69.3. Алтны геологийн судалгаа, эрэл-үнэлгээ, хайгуулын ажлыг хэмжээг өсгөн нөөцийг тогтвортой нэмэгдүүлэх*
- *2.69.4. Сорьцын хяналтын албаны чадавхийг бэхжүүлж, техник технологийг шинэчлэх*

- *2.70.1. Газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн нэгж байгуулах, үйлдвэрийн дэд бүтцийн нарийвчилсан судалгаа, үйлдвэр болон дамжуулах хоолойн газрын асуудлыг шийдвэрлэх,*
- *2.70.2. Төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн хэмжээний талаар санал боловсруулах, холбогдох шийдвэрийг гаргуулах, төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах бэлтгэлийг хангах,*
- *2.72.2. Давтах аргаар ган бөмбөлөг үйлдвэрлэх цехийг ашиглалтад оруулах,*
- *2.73.1. Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр байгуулах төслийн нэгж байгуулах,*
- *2.73.2. Дэлхийн банкны санхүүжилтээр боловсруулагдсан нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн урьдчилсан ТЭЗҮ-ийг хүлээж авах,*
- *2.73.3. Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ болон БОННҮ-г Хүнд үйлдвэрийн шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэх,*
- *2.75.2. Ачааны автомашин, нийтийн тээвэр, хөдөө, аж ахуйн машин, механизмыг угсрах үйлдвэрлэлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох.*

Үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаас хамтран ажиллах санал ирүүлээгүй, яамны зүгээс тодорхой хийгдсэн ажлын биелэлтгүй 10 арга хэмжээ байна. Үүнд:
Яам толгойлон хэрэгжүүлэх 3 арга хэмжээний хэрэгжих хугацаа болоогүй тул үнэлгээ өгөөгүй.

- *2.65.2. Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын уялдаа холбоог хангах, /УУБГ/*
- *2.70.4. Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилгын ажлыг гүйцэтгэж, үйлдвэрийг хүлээн авч ашиглалтад оруулах, /ХҮБГ/*
- *2.71.3. Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулж, ашиглалтад оруулах, /ХҮБГ/*

Бусад байгууллага хариуцан хэрэгжүүлэх 7 арга хэмжээнд үнэлгээ өгөөгүй:

- *2.48. 7. "Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 21 аймагт 100 нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад санхүү, эрх зүйн дэмжлэг үзүүлж ажиллах /ХХААХҮЯ/*
- *2.59.10. Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн хайгуул, геологийн судалгааны ажлыг гүйцэтгэх /АМГТГ, ЦЭКАА/*
- *2.92.2. Хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах чиглэлээр судалгаа хийх /БХБЯ/*
- *2.106.1. Метан хийн нөөцийг бүрдүүлэх болон салбарын хөгжлийг дэмжсэн бүтэц зохион байгуулалтыг бий болгох /ЭХЯ/*
- *3.2.33.11. Шинжлэх ухаан, танин мэдэхүйн мэдээллийн төв байгуулах барилга, байгууламжийн дотоод зураг төсөл, үзүүлэн бэлтгэх, макет, үзвэрүүдийг хийх, тохижолт болон бусад арга хэмжээг зохион байгуулах /ЦЭКАА/*
- *4.1.3.1. Байгаль орчны үнэлгээ, аудитаар дамжуулан ашиглагч нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх /БОАЖЯ/*
- *4.2.3.2. Ус ашиглалтыг бүрэн тоолууржуулж, хаягдал бохир усыг цэвэрлэж, дахин ашиглалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах /БОАЖЯ/*

**Дөрөв. Дүгнэлт**.

Яамны 2016-2017 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан 15 арга хэмжээний биелэлт 87,1%, 2017 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан 13 арга хэмжээний биелэлт 65,0%-тай байна.
Мөн 2017 онд хэрэгжүүлэх 13 арга хэмжээ, үүнээс яам толгойлон хэрэгжүүлсэн, Тавантолгойн ордыг иж бүрэн ашиглах төслийг боловсруулж, хэрэгжүүлэх, уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах, уул уурхайн судалгааны нэгж байгуулах талаар санал боловсруулах, холбогдох байгууллагад хүргүүлж

шийдвэрлүүлэх, нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэрийн төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн хэмжээний талаар санал боловсруулах, холбогдох шийдвэрийг гаргуулах зэрэг ажлууд удаашралтай байна.

Бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний биелэлт гаргахад бэрхшээлтэй, тухайн асуудлаар санал авах, хамтран ажиллах талаар үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаас ханддаггүй бэрхшээл давтагдаж байна.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний ерөнхий гүйцэтгэл 2017 оны жилийн эцсийн байдлаар 68,4 хувьтай үнэллээ. Төлөвлөгдсөн арга хэмжээнээс 19 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 33 арга хэмжээ 70 хувь, 23 арга хэмжээ 40 хувийн тус тус хэрэгжилттэй, тасарсан арга хэмжээ байхгүй.

**Тав. Зөвлөмж**.

- Тайлант хугацаанд хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээний хэрэгжилтийг хангах, зорилтот түвшинд хүргэх, ажлын гүйцэтгэлийг эрчимжүүлэх.
- Бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний биелэлт гаргахад бэрхшээлтэй, тухайн асуудлаар санал авах, хамтран ажиллах талаар үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаас ханддаггүй, яамнаас биелэлт гардаггүй бэрхшээл давтагдаж байгааг анхаарч яамны зүгээс бусад байгууллагатай хамтран ажиллах талаар идэвхи санаачлага гаргаж ажиллах.
- Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг тухайн жилд хүрэх түвшин, зарцуулсан хөрөнгийн хэмжээг төлөвлөгдсөн дүнтэй нь харьцуулан гаргаж байхад бодлогын газрууд анхаарч ажиллах шаардлагатай байна.

ЗГҮАХ-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хийсэн үнэлгээний тайланг хавсаргав.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

2018/01/18

**ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ**

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

01/18/2018

2017 оны жилийн эцэс

| ЗГҮАХ-т тусгагдсан, зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэг жүүлэх байгууллага | Зарцуулсан санхүүгийн эх үүсвэр (сая төгрөг) | Зорилтот түвшин (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр, сая төгрөг) / Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хэрэгжилтийн хувь: Хүрсэн түвшин, үр дүн | % |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| **Тэргүүлэх зорилт №1. Эдийн засагт үүссэн хүндрэлийг богино хугацаанд даван туулж, макро эдийн засгийн тэнцвэрийг хангах, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, түүхий эдийн үнээс хэт хамааралтай байдлыг бууруулж, төлбөрийн тэнцлийн эрсдэлийг багасгах, дунд хугацаанд учирч байгаа өрийн дарамтыг бууруулах, эдийн засгийг дархлаатай болгох, улмаар эдийн засаг дунд хугацаанд тогтвортой тэлэх бодлогыг баримтална.** | | | | | | | | |
| 1.24. “Эрдэнэс Монгол” компани болон Оюутолгой төслийн үйл ажиллагааг эрчимжүүлж, Тавантолгой, стратегийн ач холбогдол бүхий бусад ордыг эдийн засгийн эргэлтэд оруулна. | 1 | Тавантолгойн ордыг иж бүрэн ашиглах төслийг боловсруулж, хэрэгжүүлэх | 2017 | УУХҮЯ | | Иж бүрэн ашиглах гэрээ байгуулах<br>- | Тавантолгойн ордыг иж бүрэн ашиглах ажлыг эрчимжүүлэх зорилгоор харьцуулсан судалгаа хийж, санал дүгнэлт, зөвлөмж боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг УУХҮЯ-ны ТНБД-ын 2017 оны А/67-р тушаалаар байгуулан Эрдэнэс Тавантолгой ХК, Энержи Ресурс ХХК -тай хамтран орд ашиглах харьцуулсан тооцоо, судалгааг хийж Тавантолгойн коксжих нүүрсний ордыг иж бүрэн ашиглах боломжит хувилбарыг боловсруулсан. Мөн Энержи Ресурс компанийн Ухаа Худаг уурхайн 0-р давхаргын нүүрстэй “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Цанхийн баруун хэсгийн 3, 4, 0-р давхаргын чанар муутай нүүрсийг хольж баяжуулан үр дүнг тодорхойлох үүргийг УУХҮ-ийн сайдаас Эрдэнэс Таван Толгой болон Энержи Ресурс компаниудад өгсний дагуу тус компаниуд анхдагч хэлэлцээрийг эхлүүлээд байна.<br>- Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, УИХ-ын гишүүн Л.Энхболд нарын хамт 2017 оны 11 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд Таван толгойн бүлэг ордод олборлолт, баяжуулалт хийж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа, нөхцөл байдалтай газар дээр нь очиж танилцсаны дагуу "Таван толгойн ордыг иж бүрэн | 40 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ашиглах ажлыг эрчимжүүлэх тухай" ЗГ-ын тогтоолын төслийг боловсруулж холбогдох байгууллага, яамдаас санал авахаар хүргүүлээд байна. | |
| | 2 | Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх | 2016-2020 | УУХҮЯ | | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 9,600,000<br>Далд уурхайн ажлын гүйцэтгэл 25 хувь | Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд далд уурхайн босоо амны малталтууд, хөндлөн нэвтрэлтүүд, туслах дэд бүтцийн ажлууд ахицтай үргэлжилж байна. 2017 оны 3 дугаар улирлын байдлаар хос налуу амын нийт нэвтрэлт (конвейерийн налуу ам, үйлчилгээний налуу ам) 1600 метр болоод байна. Далд уурхайн 2 дугаар босоо аманд 1284 метр нэвтрэлт хийхээс 2017 оны 11 дүгээр сарын байдлаар 1268 метрт хүрээд байгаа бөгөөд 2018 оны нэгдүгээр сард 1284 метрт хүрэхээр тооцоолж байна. 5 дугаар босоо аманд 1178 метр нэвтрэлт хийхээс 2017 оны 11 дүгээр сарын байдлаар 1007 метрт хүрээд байгаа бөгөөд 2018 оны эхээр 1178 метрт хүргэхээр төлөвлөөд байна. Хөндлөн/хэвтээ нэвтрэлийн ажлууд 6101 метрт хүрсэн бөгөөд гүйцэтгэл төлөвлөгөөний дагуу ахицтай явж байна. Төслийн нийт капитал хөрөнгө оруулалтын төсөв 5.34 тэрбум ам доллар бөгөөд нийт 1.4 тэрбум ам.долларыг Монгол компаниудтай гэрээлээд байна. | 70 |
| | 3 | Цагаан суварга төслийг хэрэгжүүлэх | 2016-2020 | УУХҮЯ | | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 1,300,000<br>Санхүүжилт бүрэн хийгдэх | Цагаан суваргын зэс-молибдений ордын уулын баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулах ажлын явц 46.1 хувийн биелэлттэй бөгөөд цаашид төслийг бүрэн хүчин чадлаар ашиглалтад оруулахад 600.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа бөгөөд уг санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор Үндэсний хөгжлийн газраас боловсруулсан "Монгол Улсын 2018-2021" оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөлд тусгуулаад байна. Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийнхурлаар ордын зэсийн исэлдсэн хүдрийн нөөцийн тодотгол, жилд 5000 тонн катодын зэс үйлдвэрлэх үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэж хүлээн аваад байна. | 70 |
| **Тэргүүлэх зорилт №2.1. Макро тэнцвэрийг бататгасан олон тулгуурт дотоодын үйлдвэрлэлд түшиглэсэн, тогтвортой эдийн засгийг бий болгон Монгол Улсын үндэсний нийт орлогыг нэмэгдүүлж, дундаж-дээгүүр орлоготой орнуудын эгнээнд буцаан оруулна.** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.11. Чөлөөт бүсүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж ажиллана. | 3 | Замын-Үүд чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулах, улмаар Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төслийн хоёрдугаар ээлжийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх | 2017-2020 | БХБЯ | | Чөлөөт бүсийн хот төлөвлөлтийн баримт бичигтэй болох, дэд бүтцийн 2 дугаар ээлжийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэх | 2017 оны 05 сарын 12-15-ны өдрүүдэд БНХАУ-д зохион баягуулагдсан "Бүс ба Зам" уулзалтанд МУ-ын ерөнхий сайд оролцохтой холбогдуулан айлчлалын удирдамж, хэлэлцээрийн сэдэвт тусгуулах саналыг ГХЯ-нд хүргүүлсэн. Мөн Талын зам болон "Бүс ба Зам" санаачлагыг уялдуулах тухай Засгийн газар хоорондын санамж бичгийн төсөлд ГХЯ-д 2017.05.02-ны өдрийн 01/1307 тоот, 2017.05.25-ны өдрийн 02/1577 тоот албан бичгээр тус тус санал өгсөн. | 70 |
| 2.17. Шатахууны үнийг дэлхийн зах зээлийн үнэтэй уялдуулан үнийн дарамтыг бууруулна. | 1 | Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийг шинэчлэн найруулах | 2017-2018 | УУХҮЯ | | -<br>Холбогдох байгууллагуудтай хамтарсан ажлын хэсэг байгуулж, хуульд өөрчлөлт оруулах | УУХҮС-ын 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/06-р тушаалаар “Газрын тосны бүтээгдэхүүний тухай” хуулийг шинэчлэн найруулах, төслийг боловсруулах, хянах, эцэслэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг, АМГТГ-ын даргын 2017 оны 04 дүгээр сарын 14-ний өдрын а/45-р тушаалаар хуулийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах, хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, холбогдох тооцоо судалгааг хийх, төслийг боловсруулах үүрэг дэд ажлын хэсгийг тус тус байгуулж ажиллав. Дэд ажлын хэсэг АМГТГ-ын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 1/9248 тоот албан бичгээр хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн саналыг ирүүлсэн. Мөн тус зорилтын хүрээнд Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн эрх зүйн орчныг баталгаажуулах” төслийн хүрээнд хийгдсэн Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн хийдэл, зөрчил, давхардалын судалгааг судлаж, санал дүгнэлтийг боловсруулав. Санал дүгнэлтийг үндэслэн Газрын тосны бүтээгдэхүүний тухай болон холбогдох бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах саналын томъёоллыг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд 02/2598 тоот албан бичгээр хүргүүлээд байна. | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 3 | Алслагдсан бүс нутгийн шатахууны үнийг төвийн бүстэй ойролцоо түвшинд барих бодлогыг баримтлах | 2016-2020 | УУХҮЯ | | Газрын тосны бүтээгдэхүүний хил үнэ, валютын ханшийн өөрчлөлт болон бусад холбогдох зардалтай уялдуулан шатахууны жижиглэн борлуулж буй үнийн зохицуулалтыг хийх, мөн тээвэр ложистикийн зардал, тухайн бүс нутгийн хилийн боомтоор газрын тосны бүтээгдэхүүн импортлох боломжийг судлах | “Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах асуудлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтарсан зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг Засгийн газрын 2016 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 15 дугаар тогтоолоор шинэчлэн байгуулж ажиллав. Зөвлөлийн хуралдааныг нийт 3 удаа зохион байгуулж холбогдох зөвлөмжийг Засгийн газарт хүргүүлж ажиллав. Үүний дунд Засгийн газрын 2016 оны 109, 166, 2017 оны 34 дүгээр тогтоолуудаар тус тус автобензин, дизелийн түлшний онцгой албан татварыг тодорхой хэмжээгээр бууруулах, жижиглэнгийн үнийг тогтвортой байлгах арга хэмжээг авсан. Олон улсын валютын сантай хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд автобензин, дизель түлшний онцгой албан татварын хэмжээг Засгийн газрын 2017 оны 207, 309 дүгээр тогтоолоор тус тус үе шаттайгаар нэмэгдүүлсэн хэдий ч импортлогч компаниуд татан авалтыг нэмэгдүүлж, нөөц бүрдүүлэх замаар жижиглэн борлуулалтын үнийг тогтвортой хадгалж ирсэн. Гадаад зах зээл дээрх газрын тосны үнэ, шатахууны импортын үнийн өсөлт, валютын ханш, онцгой албан татварыг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор шатахууны жижиглэн борлуулалтын үнэ зайлшгүй нэмэгдэх нөхцөл, шаардлага үүсээд байгаа талаар импортлогч компаниуд, мэргэжлийн холбоод удаа дараа мэдэгдсэн. Иймээс үүсээд байгаа нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлын талаар Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Засгийн газрын хуралдаанаас гарсан тэмдэглэлийн дагуу холбогдох тооцоолол, судалгаа хийж, хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулан 2018 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01/52 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 6 | Шатахуун импортлох, үйлдвэрлэх, хадгалах, бөөн болон жижиглэнгээр борлуулах үеийн чанарын хяналтын тогтолцоог сайжруулах | 2016-2020 | УУХҮЯ | | Холбогдох байгууллагуудтай хамтарсан ажлын хэсэг байгуулж, судалгааны ажлыг эхлүүлэх | Улаанбаатар хот болон томоохон суурин газруудад бензин, түлшний чанарын шаардлагыг Евро-5 стандартад шилжүүлэх ажлын хүрээнд Үндэсний стандартын төсөл боловсруулан Стандартчиллын Үндэсний хорооны 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн батлуулав. Мөн АНУ-ын NFPA-58 стандарт, дүрмийн орчуулгад үндэслэн Монгол орны онцлогт тохирсон Үндэсний стандартын төсөл боловсруулах Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. “Шингэрүүлсэн шатдаг хийн хэвийн хорогдлын норм”, “Шингэрүүлсэн шатдаг хийн хэвийн хорогдлыг тооцоолох аргачлал”-ын төслийг боловсруулж “Шингэрүүлсэн шатдаг хийн хэвийн хорогдлын норм”-ыг Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 04-ний 03 дугаар тогтоолоор батлуулсан ба “Шингэрүүлсэн шатдаг хийн хэвийн хорогдлыг тооцоолох аргачлал”-ыг боловсруулаад байна. Шатахууны чанарын хяналтын тогтолцоог сайжруулах талаар Ашигт малтмал, газрын тосны газар болон БНСУ-ын Газрын тосны бүтээгдэхүүний чанар, хангамжийн газар /К-Петро/ хооронд 2017.04.19-ний өдөр “Техникийн Хамтын Ажиллагааны Харилцан Ойлголцлын САНАМЖ БИЧИГ” байгуулж судалгаа, хамтын ажиллагааг эхлүүлээд байна.<br>Мөн “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-т холбогдох зорилт, арга хэмжээг тусгуулсан.Евро-5 стандартын шатахууныг хэрэглээнд өргөнөөр нэвтрүүлэхэд борлуулалтын үнийн асуудлыг ард иргэдэд санхүүгийн хүндрэл багатайгаар шийдвэрлэх шаардлага үүсээд байгаа бөгөөд уг асуудлыг “Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах асуудлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтарсан зөвлөл”-ийн 2017 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн Зургаадугаар хуралдаанаар хэлэлцүүлсэн. Тус хуралдаанаас Евро-5 стандартын чанарын шаардлага хангасан шатахууны хэрэглээг нэмэгдүүлэх, үнийг ялгавартай тогтоох, цаашид автобензин, дизель түлшний онцгой албан татварын хэмжээг чанар, стандарттай уялдуулан тогтоох хууль, эрхзүйн орчинг бүрдүүлэх ажлыг зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Сангийн яам болон шатахууны худалдаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд даалгасан зөвлөмж гаргасан.<br>Тус зөвлөмж болон дээрх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд Евро-5 стандартад нийцсэн автобензин, дизель түлшний хэрэглээг нэмэгдүүлэх, чанарын шаардлага хангахгүй байгаа автобензин, дизель түлшний импорт, борлуулалт, үйлдвэрлэлийг хязгаарлах, онцгой албан татварыг чанар, стандарттай уялдуулан тогтоох хууль, эрхзүйн орчин бүрдүүлэх зорилгоор Онцгой албан татварын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, танилцуулга, үзэл баримтлалыг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлүүлэхээр 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 01/2756 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 7 | Гашуун сухайт, Ханх, Хавирга зэрэг боомтуудаар бүтээгдэхүүн тогтмол импортлох ажлыг эхлүүлэх, улмаар тээвэр ложистикийн зардлыг бууруулах, өртгийг багасгах судалгаа хийх | 2016-2020 | УУХҮЯ | | Холбогдох байгууллагуудтай хамтарсан ажлын хэсэг байгуулж, судалгааны ажлыг эхлүүлэх | Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн- Сэхэ боомтуудаар автоцистернээр шатахуун импортлох зорилтын хүрээнд Монгол, Хятадын зам тээврийн болон холбогдох байгууллагуудын хамтарсан ажлын баг Хөх хотын боловсруулах үйлдвэрээс Ганц мод-Гашуун сухайтын боомтоор Цогтцэций, Ханбогд хүртэл шатахуун тээвэрлэх замын маршрутыг судлан тээвэрлэлт хийх боломжтой тухай дүгнэлт гаргасан. Хятадын “Чайна Ойл” компани Хөх хотын нефть боловсруулах үйлдвэрээс Ганцмод-Гашуун сухайт боомтоор газрын тосны бүтээгдэхүүн нийлүүлэх бэлтгэл ажлыг хангаж байгаа талаар 2016 оны бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээний уулзалтын үеэр мэдэгдэж байсан боловч Тянжин боомтод гарсан ослын улмаас Хятадын талаас Ганц модны боомт дээр аюултай бүтээгдэхүүн тээвэрлэх тусгай терминал байгуулах шаардлага тавьсантай холбоотойгоор тус ажил хойшлогдоод байна. Иймд МУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны комиссын 2016 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн XIV хуралдааны үеэр Монгол талаас Бургастай, Гашуунсухайт, Шивээхүрэн, Баянхошуу, Бичигт, Хавирга зэрэг боомтуудаар шатахуун импортлох хүсэлтийг Хятадын талд тавьсан ба талууд судалж үзэхээр тохиролцсон. Мөн 2017 оны 03 дугаар сард БНХАУ-ын Чайна Ойл компанийн төлөөлөлтэй хийсэн газрын тосны бүтээгдэхүүний үнэ, хангамж, боомтуудын талаарх уулзалт, хэлэлцээрийн үеэр Гашуунсухайт, Шивээхүрэн, Бургастай зэрэг боомтуудаар шатахуун нийлүүлэх асуудлаар санал солилцсон ба дээрх боомтуудаар шатахуун импортлох боломжийн талаарх судалгааг хамтран хийхээр тохиролцов. Гаалийн ерөнхий газрын Хөвсгөл аймаг дахь төлөөлөгч болон Буряд улсын гаалийн газрын төлөөлөгчдийн 2016 оны 11 дүгээр сарын 02-ний өдөр “Ханх” боомт дээр хийсэн уулзалтаар тус боомтоор газрын тосны бүтээгдэхүүн импортлох боломжийн талаар санал солилцож уг асуудлаар УУХҮЯ нь бодлогын хүрээнд дэмжиж ажиллах талаар Улаан-Үүдийн консулын газарт мэдэгдсэн. | 70 |
| **Тэргүүлэх зорилт №2.2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын тогтвортой хөгжлийг хангах зорилгоор “ЭРҮҮЛ ХҮНС-ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН” үндэсний хөтөлбөр, “ҮЙЛДВЭРЖИЛТИЙН 21:100” хөтөлбөр, “ҮНДЭСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ” хөтөлбөр, “МАХ, СҮҮНИЙ АНХДУГААР АЯН”-ыг шинээр эхлүүлж, “АТРЫН-III АЯН”-ыг үргэлжүүлэн хэрэгжүүлнэ.** | | | | | | | | |
| 2.48. Үйлдвэржил | 6 | “Үйлдвэржилт 21:100” | 2016-2020 | ХХААХҮЯ | | - | ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2016 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн А/157 дугаар тушаалаар байгуулагдсан “Үйлдвэржилт 21:100 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| тийн 21:100 хөтөлбөрийг хэрэгжүүлж, импортыг орлох экспортын чиглэлийн тэргүүлэх болон жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, худалдаа, үйлчилгээний салбарын татвар, эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлнэ. | | хөтөлбөрийг боловсруулан батлуулах | | | | Өнөөгийн байдлын судалгаа хийж, аж үйлдвэрийн зураглал гаргах, хөтөлбөрийн төслийг боловсруулж батлуулах | хөтөлбөр"-ийг боловсруулж батлуулах үүрэг бүхий Ажлын хэсэгт ажиллав. Ажлын хэсгээс Монгол Улсад хүнд, хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслүүдийн танилцуулгыг боловсруулан Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж Засгийн газрын хуралдааны 2016 оны 60 дугаар тэмдэглэл гарсан. Уг тэмдэглэлд Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд заасны дагуу Хөгжлийн бодлогын баримт бичгийг боловсруулах тухай санал гарсны дагуу ажлын хэсэг "Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрийг боловсруулж, яамдаас санал авч Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр бэлэн болгосон байна. Энэхүү ажлын хүрээнд Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл болон салбарын эрдэмтэн, доктор, ААН-үүдийн удирдлагуудтай 21:100 хөтөлбөрийн төслийг хэлэлцүүлэх ажлыг УУХҮЯ-нд 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулав. Хүнд үйлдвэрийн зөвлөлөөс 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 17/47 тоот албан бичгээр ирүүлсэн саналыг Ажлын хэсэгт хүргүүлэв. ХХААХҮЯ-ны 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 01/1470 дугаар албан бичгийн хавсралтаар ирүүлсэн "Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийн төсөлд санал боловсруулж, 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 01/1159 тоотоор хариу хүргүүлэв. | |
| | 7 | "Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 21 аймагт 100 нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад санхүү, эрх зүйн дэмжлэг үзүүлж ажиллах | 2016-2020 | ХХААХҮЯ | | Улсын төсөв, гадаад эх үүсвэр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 301,000 | Хөтөлбөр батлагдсаны дараа дүрэм, журам гарна. Хугацаа болоогүй. | /-/ |
| | | | | | | Нөхцөл байдлын судалгаанд үндэслэн үйлдвэржилтийн зураглал гаргаж, аймаг, орон нутгийн нөөц боломжид тулгуурласан үйлдвэрүүдийн ТЭЗҮ-ийг боловсруулах | | |

**Тэргүүлэх зорилт №2.3. Геологи, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчинг бүрдүүлэх, уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг хангах, олон улсын эрдсийн зах зээл дэх Монгол Улсын өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.**

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.59. Монгол орны геологийн зураглал, ерөнхий эрэл, агаарын геофизик, геохими, гидрогеологи, геоэкологийн судалгааны ажлын хэмжээг нэмэгдүүлэх замаар уул уурхайн салбарын тогтвортой хөгжлийг дэмжинэ. | 1 | Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажлын хэмжээг нэмэгдүүлж, нутаг дэвсгэрийн 45 хувийг хамруулах | 2016-2020 | УУХҮЯ | Батлагдсан – 5436,2 Гүйцэтгэл - 5251,3 Санхүүжилт – 5251,3 | Улсын төсөв 30,700.0<br>Нутаг дэвсгэрийн 41 хувийг хамруулж, геологийн тогтоц, ашигт малтмалын хэтийн төлвийн үнэлгээг өгөх | Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн Монгол Алтай-50, Ар чулуут-50, Хайрхан уул-50, Дөрөө нуур-50, Булган-50, Буурал хайрхан-50, Тойромын хөндий-50, Хөх нуур-50, Тахилт-50, Эргэлийн зоо-50, Алтайн нуруу-50, Дэлгэрхаан-50 төслүүдийн дуусгав. Төслүүдийн үр дүнг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн холбогдох дүгнэлтийг гаргуулсаны үндсэн дээрсайдын А/02, А/56, А/57, А/59, А/60, А/61, А/106, А/107, А/134, А/135, А/170, А/171 дүгээр тушаалуудаар хүлээн авсан. Үүний үр дүнд 2017 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаарГеологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн судалгааны ажлаар нийт нутаг дэвсгэрийн 37,4%-ийг бүрэн бүрхсэн байна.<br>Мөн 2018 онд үргэлжлүүлэх 27, шинээр 6, нийт 33 төслийг хэрэгжүүлсэний үр дүнд нутаг дэвсгэрийн 5%-ийг Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажилд нэмж хамруулсан байна.<br>Эдгээр ажлуудын үр дүнд Монгол орны нийт нутаг дэвсгэрийн Геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн судалгааны түвшинг 42,4%-д хүргээд байна. | 70 |
| | 2 | Улсын геологийн 1:200000-ны масштабын зургийг нэгтгэх | 2017-2020 | УУХҮЯ | Батлагдсан - 502.4 Гүйцэтгэл - 502.4 Санхүүжилт - 502.4 | Улсын төсөв 3,900.0<br>К номенклатурын хэмжээнд ажлыг эхлүүлэх | Улсын геологийн 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох ажлын хүрээнд УГЗ-200-Төв Монгол-VI төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлж, сайдын 2017 оны А/108 дугаар тушаалаар хүлээн авсан. Ингэснээр нийт нутаг дэвсгэрийн 90%-д 1:200000-ны масштабын иж бүрдэл зураг зохиох ажлыг бүрэн гүйцэтгээд байна.Үлдсэн нутаг дэвсгэр буюу 10%-ийг хамарч буй УГЗ-200 зураг зохиох ажлын хүрээнд Дорнод Монгол-VI, Дорнод Монгол-VII, Төв Монгол-V төслүүдийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхэд бэлэн болсон. 1:200000-ны масштабын иж бүрдэл зургийг нэгтгэх ажлыг “К” хавтгайн хэмжээнд үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. Уг төслийн 2017 оны төлөвлөгөө, төсвийг сайдын 2017 оны А/96 дугаар тушаалаар, төлөвлөгөө, төсвийн тодотголыг А/241 дүгээр тушаалаар тус тус батлан хэрэгжилтийг ханган ажиллав. Мөн төслийн 2017 оны хээрийн судалгааны ажлын үр дүн-анхдагч материалыг хүлээн авсан. | 70 |
| | 3 | Монгол Улсын баруун өмнөд | 2016-2020 | УУХҮЯ | Батлагдсан – | Улсын төсөв 5,700.0 | Агаарын геофизикийн Алтай-1, Алтай-2, Ховд-1 төслүүдийн 2017 оны ажлын төлөвлөгөө, төсвийг сайдын | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэсгийг хамарсан талбайд агаарын геофизикийн цогцолбор судалгааны ажлыг хэрэгжүүлэх | | | 1972,0 Гүйцэтгэл 1303,3 Санхүүжилт - 1303,3 | Алтай-I, Алтай-II төслийн үр дүнг хүлээн авч нутаг дэвсгэрийн 13 хувийг хамруулах, Ховд-I талбайд ажлыг эхлүүлэх | 2017 оны А/96 дугаар тушаалаар батласан. Төслүүдийн хээрийн судалгааны ажлын хэмжээ, арга аргачлалд тодотгол хийж А/241 дүгээр тушаалаар батлан хэрэгжилтийг ханган ажиллав. Төслүүдийн 2017 оны хээрийн судалгааны ажлын үр дүн-анхдагч материалыг хүлээн авсан. Алтай-1, Алтай-2 төслүүдийн үр дүнгийн тайлантай танилцаж, ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхэд бэлтгэсэн. ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцэж хүлээн авснаар нутаг дэвсгэрийн 13,2 хувь хамрагдна. | 40 |
| | 4 | Монгол Улсын нутаг дэвсгэрийг хамарсан геохимийн судалгаа хийх | 2017-2020 | УУХҮЯ | - | Улсын төсөв 2,100.0<br>Геохимийн суурь судалгааны ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд хийж эхлэх | Монгол орны нутаг дэвсгэрийг 1:1000000-ын масштабын геохимийн судалгааны ажилд хамруулах зорилгоор төслийг 2018 оноос хэрэгжүүлэх төлөвлөгөө, төсвийг боловсруулан МУ-ын нийгэм, эдийн засгийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгуулсан. Мөн Улсын 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгуулахаар саналыг бэлтгэн СЯ-нд хүргүүлсэн. | 40 |
| | 5 | Дэд бүтцийн бүтээн байгуулалт хийгдэх газар болон томоохон хот суурин газрын геоэкологийн болон гидрогеологийн сэдэвчилсэн судалгааны ажил хийх | 2017-2020 | УУХҮЯ, БОАЖЯ | Батлагдсан – 329,1 Гүйцэтгэл – 329,1 Санхүүжилт – 329,1 | Улсын төсөв 1,100.0<br>Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд геоэкологи, гидрогеологийн сэдэвчилсэн судалгааны ажлыг эхлүүлэх | Улаанбаатар хотын геоэкологи, гидрогеологийн нөхцлийг нарийвчлан үнэлэх сэдэвчилсэн судалгааны ажлыг 2017 онд эхлүүлэхийн тулд геологийн даалгаврыг УУХҮЯ-ны ТНБД-ын шийдвэрээр, төлөвлөгөө, төсвийг сайдын А/96 дугаар тушаалаар тус тус баталсан. Төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажил гүйцэтгэх гэрээ байгуулан хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Төслийн 2017 оны судалгааны ажлын үр дүн-хээрийн ажлын анхдагч материалыг хүлээн авсан. | 70 |
| | 6 | Эрдэс баялгийн хэтийн төлөв | 2017-2020 | УУХҮЯ | 2. Батлагдсан | 14,900.0 | 1. Монгол орны газрын ховор элементийн металлогени, түүний хэтийн төлвийн судалгааны ажлын үр дүнгийн | 40 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүхий хүдрийн бүс, сав газар, улсын хил орчмын нутаг дэвсгэр, дэд бүтцийн бүтээн байгуулалтын төлөвлөлттэй уялдуулан сэдэвчилсэн судалгааны төсөл хэрэгжүүлэх | | | -30.8 Гүйцэтгэл - 15.9 Санхүүжилт - 15.9 3. Батлагдсан -407.2 Гүйцэтгэл - 407.2 Санхүүжилт - 407.2 4. Батлагдсан -1884,5 Гүйцэтгэл - 1884,5 Санхүүжилт - 1884,5 5. Батлагдсан -568,8 Гүйцэтгэл - 568,8 Санхүүжилт - 568,8 | Үнэт, өнгөт, холимог металлын хэтийн төлвийн судалгааны ажлыг хэрэгжүүлж эхлэх | тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн холбогдох дүгнэлтийг гаргуулсаны үндсэн дээр сайдын А/58 дугаар тушаалаар хүлээн авсан.<br>2. Баян-Өлгий, Ховд, Увс, Говь-Алтай аймгуудын нутгийн хэмжээнд Баруун Монголын цул сульфид-2013 төслийг хэрэгжүүлж үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхэд бэлэн болгосон.<br>3.Сансрын зургийн тайлалт-2013, Металлогени-2014 төслүүдийн 2017 оны ажлын төлөвлөгөө, төсвийг сайдын А/96 дугаар тушаалаар, төслүүдийн төсөв, төлөвлөгөөнд тодотгол хийж сайдын А/241 дүгээр тушаалаар тус тус батлуулан хэрэгжилтийг ханган ажиллав. Төслүүдийн үр дүнг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхэд бэлэн болсон.<br>4. Бүс нутгийн хөгжлийг хангах, эрдэс түүхий эдийн нөөц, баялгийг өсгөх зорилгоор нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд тархсан голлох ашигт малтмалын судалгаа (АМС-2017)-ны ажлыг 2017 оноос хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөгөө, төсвийг сайдын А/96 дугаар тушаалаар, төсвийн тодотголыг А/241 дүгээр тушаалаар тус тус батлуулсан. Ажлын геологийн даалгаврыг боловсруулан батлуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан, хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Төслийн 2017 оны хээрийн судалгааны ажлын үр дүн-анхдагч баримт материалыг хүлээн авсан.<br>5. Налайхын нүүрсний ордын геологийн тогтоц, нөөцийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор геофизикийн чичирхийллийн судалгааны ажлыг 2017 онд төлөвлөн төлөвлөгөө, төсвийг сайдын А/96 дугаар тушаалаар батлуулсан. Геологийн даалгаврыг боловсруулан батлуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхэд бэлэн болсон. | |
| | 7 | Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн хайгуул судалгаа, ашиглалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох | 2016-2017 | УУХҮЯ | | Монгол Улсын эзэмших хувь хэмжээ, нөөц ашигласны төлбөрийн хэмжээг оновчтой зохицуулах эрх зүйн орчин бүрдэх, орд ашиглах гэрээ, хувьцаа эзэмших гэрээ, хамтарсан компани байгуулах | Уул уурхайн, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/51 тоот тушаалаар “Монгол Улсын хэмжээнд цацраг идэвхт ашигт малтмал эрэх хайх, олборлох, боловсруулах үйл ажиллагааны өнөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх асуудлаар санал боловсруулж ажллах үүрэг бүхий” Ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд энэхүү ажлын хэсэгт холбогдох байгууллагууд орж ажиллан “Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн талаар санал дүгнэлт боловсруулж ажилласан. Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг шинээр батлагдсан “Хууль | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гэрээний загвар зөвлөмж гарах | тогтоомжийн тухай” хуулийн дагуу дахин боловсруулж Ажлын хэсэг болон ХЗДХЯ-нд хүргүүлсэн | |
| | 8 | Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн геологи хайгуулын ажлыг төлөвлөх | 2016-2020 | АМГТГ | | Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн геологи хайгуулын ажлыг шинэ талбайд эхлүүлэх бэлтгэл ажлыг хангах | Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн геологи хайгуулын ажлыг шинэ талбайд эхлүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 40 |
| | 9 | Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн нөөц бүхий ордод стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгох, хамтарсан компани байгуулах | 2016-2020 | УУХҮЯ, АМГТГ, ЦЭКАА | | Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн геологи хайгуулын ажлыг гүйцэтгэх, стратегийн хөрөнгө оруулагчдыг сонгон шалгаруулах | "Арева майнс" ХХК, "Гурван сайхан" ХХК-д цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг олгох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэж, "Орд ашиглах гэрээ"-г байгуулав.<br>Стратегийн хөрөнгө оруулагчаар Франц Улстай "Арева майнс" ХХК, Чех Улстай "Гурван сайхан" ХХК-ийг тус тус сонгон эзэмшиж байгаа ордод хамтран ажиллаж байна.<br>Эдгээр компаниудын хувьцааны Монголын Засгийн газарт ноогдох хувь эзэмшлийн асуудлыг шийдвэрэлэхээр ажиллаж байна. "Арева майнс" ХХК-ийн ордын төрийн эзэмшлийн хувь хэмжээг шилжүүлэхээр Ерөнхий сайдын захирамжаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна | 70 |
| | 10 | Цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн | 2016-2020 | АМГТГ, ЦЭКАА | | Хувийн хэвшилийн хөрөнгө оруулалт 80,000.0 | -Монгол орны цацраг идэвхт ашигт малтмал болон газрын ховор элементийн геологи, хайгуулын ажлын талаар 2017-2020 Засгийн газрын мөрийн хөтөлбөрт биелэлтийн талаар мэдээлэл бэлтгэн өгсөн.<br>-Цацраг идэвхт ашигт малтмалын нөөцийн мэдээг хагас | /-/ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хайгуул, геологийн судалгааны ажлыг гүйцэтгэх | | | | Одоогийн цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн судалгаа, геологи хайгуулын ажлыг эрчимжүүлэх | жил тутам Цөмийн Энергийн комиссын ажлын албанд хүргүүлж байна<br>- Тайланд улсын Бангкок хотод Олон улсын Атомын Энергийн Агентлагийн техникийн хамтын ажиллагааны хүрээнд "Ази, Номхон далайн орнуудын ураны геохими" RAS2019 сэдэвт семинарт 1 мэргэжилтэн оролцсон.<br>Тайлбар: Цацраг идэвхт ашигт малтмал, газрын ховор элементийн чиглэлээр хайгуул хийж буй компаниуд жил бүр хөрөнгө оруулалтын боломжоороо ажлаа гүйцэтгэж буй бөгөөд төрийн байгууллагын үйл ажиллагаанаас хамааралгүйгээр хийгдэж байна. Одоогоор аж ахуйн нэгжтэй мэдээлэл солилцох хэмжээнд ажил явагдаж байна.<br>Судалгаа, хөрөнгө оруулалт татах чиглэлээр Цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн болон хайгуулын ажлын мэдээлэл, тогтоогдсон нөөц, өнөөгийн үнэ ханш, зах зээлийн судалгаа, хэтийн төлөвийн талаарх мэдээлэл бэлтгэсэн. Мөн 2017 онд дууссан "Монгол орны газрын ховор элементийн металлогени, түүний төлөвийн судалгаа"-ны төслийн явц болон үр дүнгийн талаар танилцуулга хийгдсэн. | |
| 2.60. Олон улсын жишгийн дагуу Үндэсний геологийн алба, Үндэсний геомэдээллийн санг байгуулан, мэдээлэл түгээх үйлчилгээг хялбаршуулна. | 1 | Үндэсний геологийн алба байгуулахдаа хууль, эрх зүй, эдийн засгийн үр өгөөж, гадаад улсуудын ижил төстэй байгууллагуудын талаар иж бүрэн судалгаа хийх, санал, дүгнэлт боловсруулж, ЗГ, УИХ-аар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах, үйл ажиллагааг эхлүүлэх | 2017-2020 | УУХҮЯ | - | Хууль, эрх зүй, эдийн засгийн үр өгөөж, гадаад улсуудын судалгааг хийж, санал дүгнэлт гаргах | -Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр /AMEP/-ийн хүрээнд төсөлтэй хамтран гадаад орнуудын геологийн албадын судалгаа, хууль эрхзүйн орчны судалгаанд тулгуурлан Үндэсний геологийн алба байгуулах багийг байгуулан ажиллаж байна. Үүнд: АНУ-ын Геологийн алба USGS, Солонгосын ашигт малтмалын нөөц, геологийн шинжлэх ухааны институт KIGAM, Английн Геологийн алба British Geological Survey, Хятадын Геологийн алба Chinese Geological survey, Норвегийн Геологийн алба The Norwegian geological survey (NGU), Финляндын Геологийн алба The Geological Survey of Finland (GTK), Канадын Геологийн алба The Geological Survey of Canada, ОХУ-ын Геологийн алба A.P.Karpinsky Russian Geological Research Institute (VSEGEI), Энэтхэгийн Геологийн алба Geological Survey of India (GSI), The Geological Survey of Western Australia талаар судалгаа, харьцуулалт хийж дүгнэлт гаргасан.<br>-Олон Улсын жишгийн дагуу "Монгол Улсын Үндэсний Геологийн Алба"-ыг байгуулах хууль, эрх зүйн үндэслэлийн талаар иж бүрэн судалгаа хийсэн материалиудыг нэгтгэн гаргасан. Геологийн судалгааны төв ТӨҮГ болон Геологийн төв лабоаторийг нэгтгэх | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | асуудлыг Үндэсний геологийн алба байгуулах ажлын хүрээнд нэгдсэн зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх тухай саналыг боловсруулан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлсэн. | |
| | 2 | Үндэсний геомэдээллийн санг баяжуулах, нэгдсэн загварт оруулах, мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журмыг боловсруулах, түгээх үйл ажиллагааг боловсронгуй болгох | 2016-2020 | УУХҮЯ | Батлагдсан -323,2 Гүйцэтгэл – 323,2 Санхүүжилт – 323,2 | Төслүүдийн үр дүнгийн тайланг хүлээн авч, санг баяжуулах | -Геомэдээллийн сан-2017 төслийн 2017 оны төлөвлөгөө, төсвийг сайдын 2017 оны А/96 дугаар тушаалаар, Төслийн 2017 оны ажлын хэмжээ, арга, аргачлал, төсвийн тодотголын материалтай танилцаж ЭБМЗ-өөр хэлэлцүүлэнА/214 дүгээр тушаалаар тус тус баталсан. Төслийн 2017 оны суурин боловсруулалтын ажилтай танилцаж, анхдагч материалыг хүлээн авсан. Үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэхэд бэлэн болсон. “Геологи, уул уурхай, эрдэс баялгийн мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журам”-ын төсөлд Захиргааны ерөнхий хуулийн дагуу нөлөөллийн шинжилгээг хийж боловсруулсан. Журмын төсөлд олон нийтийн хэлэлцүүлгийг яам, агентлаг, их сургуулиуд, хүрээлэн, мэргэжлийн холбоод, Канад Улсын олборлох салбарын СЕСМИМ төсөл, Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр /AMEP/ төслийн төлөөлөл бүхий 60 гаруй мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулсан. Яам, агентлагийн цахим хуудаст байршуулан санал авч байна. Архивын ерөнхий газар, Үндэсний дата төв, Ус, цаг уур орчны судалгааны хүрээлэнгээс холбогдох саналыг авч тусгасан. Журмыг сайдын 2017 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/206 дугаар тушаалаар баталж, Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу холбогдох материалыг боловсруулан ХЗДХЯ-д 2017.09.22-ны 03/2028 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 70 |
| 2.61. Геологи, уул уурхайн салбарт хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг | 1 | Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах | 2017-2018 | УУХҮЯ | - | Хуулийн төсөл, үзэл баримтлалыг боловсруулах | -Ашигт малтмалын тухай хуульд тусгай зөвшөөрлийн олголттой холбоотой асуудлыг зохицуулах тухай саналыг Уул уурхайн тухай хууль боловсруулах ажлын хэсэгт хүргүүлсэн. Газрын хэвлийн тухай хууль, Уул уурхайн хуулийн төсөл болон бусад холбогдох хууль, тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлтэй уялдуулах талаар судалгаа хийсэн.Хайгуулын тусгай зөвшөөрөл олголтод орон нутгийн зүгээс учруулж буй хүндрэлийг судлан Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулсан.Хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналын судалгааг хийв. Үүнд: нөхөн олговор, тусгай зөвшөөрөл өргөдлөөр олгох асуудалтай холбоотой санал | 40 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| хамтран хэрэгжүүлнэ. | | | | | | | хүсэлт, хуулийн заалтын судалгаа хийсэн.Дээрх судалгаанд үндэслэн Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлд нэмэлт өөрчлөлт оруулахаар хуулийн төслийг боловсруулсан.Сангийн яамаас ирүүлсэн Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцан санал хүргүүлсэн. | |
| | 4 | Эдийн засгийн үр ашигтай төслүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх | 2016-2020 | УУХҮЯ | | Бэлэн болсон 20-иос доошгүй уурхай, уулын үйлдвэрийг ашиглалтад оруулах | 2017 онд нийт 46 аж ахуйн нэгж хүсэлт ирүүлсэн. Комисс ажлуулахаар хүсэлтээ ирүүлсэн аж ахуйн нэгжүүдтэй холбоо тогтоож бичиг баримтын бүрдэл хангасан 20 уурхай, 1 баяжуулах үйлдвэрт Улсын комисс ажиллаж, цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг өгч, хүлээн авсан. Бусад бичиг баримтын бүрдэл хангаагүй-18, бичиг баримтын бүрдэлээ ирүүлээгүй-7 аж ахуйн нэгж байна. Комисс нийт 9 удаа ажилласан. | 100 |
| | 5 | Гадаад орнуудтай хамтарсан геологийн судалгааны ажлын төслийг хэрэгжүүлэх, үр дүнгийн тайланг хүлээн авах | 2017-2020 | УУХҮЯ | 1. Төсөвгүй 2. Батлагдсан -142.4 Гүйцэтгэл - 142.4 Санхүүжилт - 142.4 | Улсын төсөв 950.0<br>Хамтран хэрэгжүүлсэн төслүүдийн үр дүнг хүлээн авах | 1. БНЧех Улсын геологийн албатай хамтран геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн "Монгол Алтай-50" төслийг хэрэгжүүлж үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн сайдын 2017 оны А/02 дугаар тушаалаар хүлээн авсан.<br>2. МУ, ОХУ, БНХАУ, БНСУ, БНКазУ-ын хамтарсан "Хойт, төв, зүүн Азийн геологийн гүний процесс ба металлогени" төслийн 2017 оны суурин боловсруулалтын ажлын төсөв, төлөвлөгөөг сайдын 2017 оны А/96 дугаар тушаалаар баталсан. Төслийн 3 дах шатны үр дүнгийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлэн хүлээн авсан. Хамтын ажиллагааны хүрээнд тухайн төслийн 4 дэх шатны төслийг 2018 оноос хэрэгжүүлж эхлэхээр Орос, Хятад, Солонгосын талуудтай харилцан тохиролцсон. | 70 |
| | 6 | Хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх талаар гадаад орнуудаас ирүүлсэн саналыг судалж, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2017-2020 | УУХҮЯ | | Улсын төсөв 5,000.0<br>Гадаад орнуудаас ирүүлсэн хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх саналыг судалж, шийдвэрлэх | ОХУ болон МУ-ын ЗГ-ын хоорондын ээлжит хуралдаанаар ОХУ-аас тайлан хүлээн авах, хилийн бүсэд геологийн судалгааны ажлыг хамтарч хийх, зарим нэг ашигт малтмалаар эрлийн судалгааг хамтарч хийхээр шийдвэрлэсэн. 2017 онд төсөв батлагдаагүй тулд хэрэгжээгүй.БНХАУ-ын ӨМӨЗО-ны Геологийн товчооноос Монгол орны өмнөд хэсэгт 1:50000-ны зураглал, ерөнхий эрлийн төсөл хэрэгжүүлэх саналыг судлан хариу хүргүүлсэн. Ирүүлсэн саналд геологийн судалгааны ажлын үр дүнд тогтоогдсон хэтийн төлөв бүхий талбайд эрэл, хайгуулын хийж хайгуулын тусгай зөвшөөрлийн давуу эрхтэйгээр авахаар тусгагдсан байсан тул холбогдох хууль, тогтоомжийн дагуу хамтран төсөл хэрэгжүүлэх боломжгүйг мэдэгдсэн. | 40 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.62. Уул уурхайн үйлдвэрлэл дэх төрийн оролцоог зохистой хэмжээнд байлгаж, Кадастрын бүртгэлийн системийг боловсронгуй болгож, тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээг хөнгөн шуурхай болгоно. | 1 | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хялбаршуулах талаар судалгаа хийж, хэрэглэгчдэд ойлгомжтой байдлаар тусгай зөвшөөрөл олгох, мэдээллийг ил тод, нээлттэй түгээх аргачлалын санал боловсруулах | 2017-2018 | УУХҮЯ | | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээ хялбар, шуурхай болох, олон нийтэд ойлгомжтой болох | 1Засгийн газрын 2017 оны 37 дугаар тогтоолоор нийт 51665 солбицол бүхий 1.61 сая гектар талбай хамарсан “Сонгон шалгаруулах журмаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицол”, 106 дугаар тогтоолоор нийт 1064479 солбицол бүхий 13.66 сая гектар талбай хамарсан “Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл өргөдлөөр олгох талбайн солбицол”, 234 дүгээр тогтоолоор нийт 5191 солбицол бүхий 431661.39 гектар талбай хамарсан “Сонгон шалгаруулах журмаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицол нэмэлтээр батлах” тогтоолыг тус тус батлуулсан.Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг нээлттэй, ил тод, шударга явуулах талаар Засгийн газрын 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 27 дугаар тэмдэглэлд заасаны дагуу холбогдох арга хэмжээг авсны үндсэн дээр цахимаар тусгай зөвшөөрөл олгох тухай Засгийн газрын 2017 оны 210 дугаар тогтоол гарсан. Тогтоолын дагуу тусгай зөвшөөрөл олгох бэлтгэлийг зохион байгуулсан боловч Тагнуулын ерөнхий газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 01/1096 тоот албан бичгийн дагуу тодорхойгүй хугацаагаар хойшлогдсон.<br>Ашигт малтмалын тухай хуульд орсон 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн, тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын зарчмаар олгох нэмэлт өөрчлөлттэй холбоотойгоор энэ асуудал эрх зүйн үндэслэлгүй болсон. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн “Үйлчилгээний хөлс тогтоох тухай” сайдын А/161 дүгээр тушаалаар батлуулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлэхээр хүргүүлсэн. ХЗДХЯ-ны Захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд 3776 дугаараар бүртгүүлсэн. | 100 |
| 2.63. Газрын тосны болон уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын ажлыг эрчимжүүлж, нөөцийг өсгөнө. | 1 | “Газрын тосны салбарт төрөөс баримтлах бодлого”-ыг шинэчлэн боловсруулах | 2016-2017 | УУХҮЯ | | Холбогдох байгууллагуудтай хамтарсан ажлын хэсгийг байгуулж, "Төрөөс газрын тосны салбарт баримтлах бодлогын | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны Б/101 –р тушаалаар “Төрөөс газрын тосны салбарт баримтлах бодлогын баримт бичиг” боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн хүрээнд Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг гаргаж, бодлогын баримт бичгийн төслийг эцэслэн боловсруулаад байна. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, холбогдох журамд нийцүүлэн бодлогын төслийн нөлөөллийн шинжилгээ, төлөвлөгөөний төсөл болон бусад мэдээлэл судалгааг боловсруулсан. Төслийг УУХҮЯ болон АМГТГ-ын цахим | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | баримт бичиг"-ийг шинэчлэн боловсруулж, батлуулах | хуудаснаа байршуулж санал авсан. Төслийн хэлэлцүүлгийн зохион байгуулаад байна. Хэлэлцүүлгээс гарсан саналыг бодлогын төсөлд тусгаж, саналын товчоог бэлтгэж байна. 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдөр бүх яамдаас санал авахаар 01/2752,Сангийн яамнаас Засгийн газраар хэлэлцүүлэх зөвшөөрөл авахаар 01/2753 тоот албан бичиг тус тус хүргүүлээд байна. | |
| | 3 | Газрын тосны салбарын хөрөнгө оруулалтын болон эдийн засаг, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх | 2016-2019 | УУХҮЯ | | Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр судалгаа хийх | Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 130 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхажлынхүрээнд 2014 оны 07 дугаарсарын 01-ний өдөрбаталсанГазрынтосныТухайхуульбатлагдахаас өмнө байгуулсанБүтээгдэхүүнхуваах гэрээнүүдийн үндсэн нөхцөлийг өөрчлөхгүйгээр Засгийн газрын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварт нийцүүлэн хэлэлцээр хийж шинэчлэх үүрэг бүхий ажлын хэсгийг Сайдын 2016 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн А/57 тоот тушаалаар байгуулсан. “Петрочайна Дачин Тамсаг” ХХК, тус компанийн эх компаниудын төлөөлөл бүхий ажлын хэсэгтэй уулзалт зохион байгуулсан.<br>- Доншен группийн ерөнхий захирал, Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн ерөнхий захиралтай 2016 оны 12 дугаар сарын 23-ны өдөр уулзаж, санал солилцсон. Уулзалтын үр дүнд хоёр тал уулзалтаар тохиролцсон асуудлуудаар протокол байгуулсан. Хэлэлцээрийг 2017 оны 03 дугаар сарын 28-ны өдөр хийж, хоёр талын саналуудыг тусгасан тэмдэглэлд 2 талаас гарын үсэг зурсан.Ашиглалтын үе шатны гэрээлэгчид бүтээгдэхүүн хуваах гэрээг өөрчлөхгүй гэсэн байр суурьтай байна.<br>- Газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулж буй кампаниудын хувьд дараах арга хэмжээг авч ажиллав. Ажлын хэсэг нийт 10 гэрээлэгчтэй уулзалт хэлэлцээр хийсний дүнд хайгуулын үе шатанд хэрэгжиж буй нийт 15 Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдээс 4 гэрээг шинэчлэн байгуулсан, 3 гэрээг шинэчлэн байгуулахад бэлэн болгож, 3 гэрээг шинэчлэхээр хэлэлцээ хийж байна. Мөн 2 гэрээний гэрээлэгч гэрээт талбайнуудыг бүхэлд нь буцаах хүсэлтийг гаргаж гэрээг шинэчлэхээс татгалзсан, 2 гэрээний гэрээлэгч гэрээнүүдийг цуцлах тухай хүсэлт гаргасан, 1 гэрээ шүүхийн маргаан эцэслэн шийдвэрлэгдээгүй байна.Газрын тосны нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөр төлөх, хуваарилах, зарцуулах журмыг 2017 оны 1-р сарын 03-ны | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өдрийн 3Г-ын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулаад байна. | |
| | 4 | Газрын тосны ордын ашиглалтыг эрчимжүүлж, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх | 2016-2020 | УУХҮЯ | | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 4,000,000.0<br>Газрын тосны ордын ашиглалтыг эрчимжүүлж, тухайн жилийн зорилтот түвшин хүртэл нэмэгдүүлэх | Монгол улсын хэмжээнд хоногт дунджаар 18,848 баррель буюу 2,552 тонн газрын тос олборлож, 18,673 баррель буюу 2,537 тонн газрын тос экспортолж байна. 2017 онд нийт 8,416,172 баррель буюу 1,121,100 тонн газрын тос олборлож, экспортлохоос /2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар/ нийт 7,624,055 баррель буюу 1,034,799 тонн газрын тос олборлож, 7,504,137 баррель буюу 1,020,391 тонн газрын тос экспортлоод байна. Олборлолтын гүйцэтгэл 90.6 хувь, экспортын гүйцэтгэл 89.2 хувьтай байна.2017 онд улсын төсөвт 191 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 198 тэрбум төгрөг төвлөрүүлж, газрын тосны борлуулалтаас Монгол Улсын Засгийн газарт ногдох орлого нь 103% аар биелсэн. | 100 |
| | 5 | Газрын тосны ордын дэд бүтэц, бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлыг эрчимжүүлэх | 2016-2020 | УУХҮЯ | | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 3,500,000.0<br>Тухайн жилийн зорилтот түвшинд хүрэх | Тамсаг XXI талбайн олборлолтын үйл ажиллагаанд эрчим хүчний найдвартай нөөц эх үүсвэрээр хангах хүрээнд БНХАУ-аас эрчим хүчний шугам татах талаар судалгаа хийсэн бөгөөд холбогдох зөвшөөрлийг авахаар Эрчим хүчний яаманд албан тоот хүргүүлээд байна. 2017 оны ажлын төлөвлөгөө, төсвийн хүрээнд Тосон-Уул XIX талбайгаас Баянхошууны хилийн боомт хүртэлх 210,7 км хатуу хучилттай авто замын 3, 4 дүгээр хэсгийнбарилгын ажил эрчимтэй явагдаж байна. Тус замын барилгын ажлын хөрөнгө оруулагч болох Петрочайна Дачин Тамсаг ХХК нь ажлын гүйцэтгэлийг тусгай хяналтын компаниар хянуулж байгаа УУХҮЯ болон АМГТГ-ын зүгээс хяналтын компанийг талбай дээр ажиллуулах тал дээр арга хэмжээ авч, дэмжлэг үзүүлж ажиллаж байна. | 70 |
| | 6 | Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд | 2016-2020 | УУХҮЯ | | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 8,000.0 | Зорилтын хүрээнд “Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах” журмыг боловсруулан батлуулахаар ажиллаж байна. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл | 40 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | өртсөн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх хууль, журмыг чанд мөрдүүлж, ил тод хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх | | | | Тухайн жилд хийхээр төлөвлөсөн байгаль орчин хамгаалах ажлыг хийх, хууль, журмыг мөрдүүлж хэвшүүлэх | ажиллагааны үеийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх тухай хууль журмын хэрэгжилтэнд хяналт, шалгалт хийх, заавар, зөвлөгөө өгөх, хэрэгжилтийг хангуулах талаар БОАЖЯ болон МХЕГ-тай хамтран ажиллаж байна. | |
| | 7 | Газрын тосны борлуулалттай холбогдсон гэрээ, хэлцлүүдийг хийж, үнэ болон худалдааны таатай нөхцөлийг бүрдүүлэх | 2016-2020 | УУХҮЯ | | Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэтэй уялдуулан газрын тосны борлуулалттай холбогдсон гэрээ, хэлэлцээрүүдэд оролцож, үнэ болон худалдааны нөхцөлийг сайжруулах | Доншен газрын тос /Монгол/ ХХК болон UNIPEC компани хоорондын түүхий тосны худалдааны гэрээний үнэ, борлуулалт, тээвэрлэлтийн өртөгийн асуудлаарх хэлэлцээрийг 2016 оны 01 дүгээр сард зохион байгуулж, гэрээг сунгасан. Петрочайна Дачин Тамсаг ХХК нь газрын тосны борлуулалттай холбогдсон гэрээ, хэлцлүүдийг хийж, үнэ болон худалдааны нөхцөлийг өмнөх жилийн нөхцөл байдалтай уялдуулан сунгасан.Тосны борлуулттай холбогдсон хэлэлцээрт,олборлосон түүхий тосны борлуулалттай холбоотой асуудлаар гэрээлэгч нь гэрээний төслийг АМГТГ-т урьдчилан танилцуулсны үндсэн дээр гэрээг эцэслэн байгуулах,түүхий тос борлуулах асуудлаар хэлэлцээ хийхдээ өмнө нь байгуулсан гэрээний нөхцөлийг бууруулахгүй, талуудад ашигтай байх нөхцөлөөр хэлэлцээ хийх,тосны борлуулалтын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, шинээр байгуулах тохиолдолд АМГТГ-т урьдчилан мэдэгдэж, зөвшөөрөл авах,түүхий тосонд шинжилгээ хийлгэж, хүнцэл болон мөнгөн усны агууламжийг тодорхойлох зэрэг нөхцлүдийг тусгасан. | 100 |
| | 8 | Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу явагдаж буй газрын тосны хайгуулын | 2016-2020 | УУХҮЯ | | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 300,000.0 | 2017 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 10 гэрээлэгчтэй БХГ-г шинэчлэх талаар уулзалт хэлэлцээр хийж, хайгуулын үе шатыг тохиролцож хайгуулын ажлыг эрчимжүүлэх талаар бодлогын зөвлөмж өгч түр зогсолт буюу моратариум дахин олгохгүй байх | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажлыг эрчимжүүлж, шинээр газрын тосны орд илрүүлэх | | | | Газрын тосны хайгуул, үнэлгээний ажил эрчимжиж, тухайн жилийн батлагдсан төлөвлөгөөт ажлыг хийж гүйцэтгэх | талаар АМГТГ-т чиглэл өгч ажиллав.Газрын тосны хайгуулын Борзон-7 болон Ар булаг-29 талбайнуудад хайгуулын өрөмдлөгийн ажил явагдаж байна. Газрын тосны илрэлтэй Галба-XI талбайн гэрээлэгчтэй хийсэн уулзалтаар газрын тосны илрэл бүхий талбайд үнэлгээний хөтөлбөр хэрэгжүүлэх, нөөцийг нарийвчлан тогтоох талаар зөвлөж өгөв. Газрын тосны хайгуулын ажлыг эрчимжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд шинээр хайгуулын 2 талбайг олон улсад нээлттэй зарласан хэдий ч захиалгын материал ирүүлээгүй байна. Газрын тосны хайгуулын Хөх нуур-18 талбайд БХГ байгуулсан Эн Пи Ай ХХК, Сулинхээр-23 талбайд БХГ байгуулсан Шунхлай энержи ХХК, Богд-4, Онги-5 талбайд БХГ байгуулсан Капкорп ХХК компаниудын газрын тос хайх аж ахуйн үйл ажиллагааны Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан, Эргэл-12 талбайд шинээр БХГ байгуулсан Смарт Ойл ХХК, Ар булаг-29 талбайд БХГ байгуулсан Макм Ойл ХХК компаниудад газрын тос хайх Тусгай зөвшөөрлийг шинээр олгосон. | |
| | 9 | Газрын тос болон уламжлалт бус газрын тосны хуримтлал байж болох газарт эрэл, хайгуулын ажлыг эрчимжүүлэх | 2016-2020 | УУХҮЯ | | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 20,000.0<br>Эрэл, хайгуул, үнэлгээний ажлыг эрчимжүүлж, тухайн жилийн батлагдсан төлөвлөгөөт ажлыг хийж гүйцэтгэх | Газрын тосны 25 талбайд Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаагаас 2016 онд Эргэл XII, Арбулаг XXIX талбайд БХГ-г гэрээг шинээр байгуулсан. Мөн нүүрсний давхаргын метан хийн 5, шатдаг занарын 3, газрын тосны 10, нийт 18 талбайд эрлийн гэрээ байгуулан, хайгуул судалгааны ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. Газрын тосны хайгуулын Номгон-IX талбайд Австрали улсын хөрөнгө оруулалттай "Голден хорд лимитэд" ХХК-тай нүүрсний давхаргын метан хийн хайгуулын үйл ажиллагаа явуулах Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулахаар хэлэлцээрийг хийж, гэрээний үндсэн нөхцөлүүдийг тохиролцон холбогдох яамдуудаас санал авч байна. | 70 |
| | 10 | Хүлэмжийн хийг бууруулах чиглэлээр газрын тосны олборлолтоос гарч байгаа газрын тосны | 2016-2018 | УУХҮЯ | | Гадаад эх үүсвэр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 200.0 | ""МонСино Петролеум инженеринг" ХХК –иас "Петрочайна Дачин Тамсаг" ХХК –ийн "Тосон–Уул XIX" талбайд газрын тос олборлолтын явцад технологийн горимоор ялгарсан уусссан хийг боловсруулж CNG гарган авах, тосонд уусссан хийг цэвэршүүлж цахилгаан үүсгүүрт ашиглах гэсэн хоёр төсөл мөн 2016 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 17/19-241 албан тоотоор "Петрочайна | 40 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | уусан хийг ашиглах чиглэлээр судалгаа хийх, ашиглах | | | | Ажлын хэсэг байгуулж, судалгааны ажлыг эхлүүлэх | Дачин Тамсаг” ХХК –иас “...тосонд уусан хийг цахилгаан үүсгүүрт хувирган ашиглах” –д зөвшөөрөл хүссэн санал ирүүлсэн. Мөн Юнигаз ХХК –иас газрын тос олборлолтын явцад ялгарч буй хүлэмжийн хийг бууруулах, уг хийг эрчим хүчний эх үүсвэрт эдийн засгийн үр ашигтайгаар ашиглах чиглэлээр судалгаа хийх болон техник эдийн засгийн үндэслэл боловсруулахад шаардагдах тоо мэдээллийг авах тухай хүсэлт ирүүлсэн. Эдгээр төслүүдийг дэмжих, хамтран ажиллах боломжийг судлах тухай саналыг АМГТГ-т 2017 оны 03 дугаар сарын 31-ний 07/737 болон 2017 оны 12 сарын 13-ны 07/2634 дугаартай албан бичгээр уламжлаад байна. | |
| | 11 | Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй талбайд ой хээрийн түймэр гарах, тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор зурвас бүсийг байгуулах | 2016-2020 | УУХҮЯ | | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 400.0<br>Зурвас байгуулах ажлыг тухайн жилийн төлөвлөгөө, төсөвт нь суулгуулах, хэрэгжүүлж хэвшүүлэх | Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй талбайд ой хээрийн түймэр гарах, тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайд зурвас бүсийг хэсэгчлэн байгуулж ажиллах талаар “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-д зөвлөсний дагуу тус компани ашиглалтын талбайд хамгаалалтын бүс байгуулсан. | 70 |
| | 12 | Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д хамруулах | 2016-2020 | УУХҮЯ | | Улсын төсөв 10.0<br>Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийг уг хөтөлбөрт хамруулан, тайланг жил бүр хүргүүлдэг болох | Энэ ажлын хүрээнд аж ахуй нэгжүүдийн “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д хамрагдсан талаар судалгаа хийсэн ба гэрээлэгч компаниудыг “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга”-д хамрагдах талаар зөвлөмж өгч ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар “Петрочайна Дачин Тамсаг” ХХК, "Петро Матад" ХХК, “Сентрал Азиан Петролеум Корпорэйшн Лимитед” ХХК-иуд уг санаачлагад хамрагдаад байна.Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ажлын алба ба Олборлох үйлдвэрлэлийн засаглалыг сайжруулах төслийн ажлын алба Кэ Пи Эм Жи Аудит ХХК-ийн хооронд байгуулсан гэрээний дагуу Кэ Пи Эм Жи Аудит ХХК нь Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Хараат бус хянагч-нэгтгэгчээр томилогдон ажиллаж байгаа бөгөөд тус газраас газрын тосны хайгуул, ашиглалттай холбоотой үйл ажиллагаа явуулж буй компаниудын талаарх мэдээллийг хүссэн тул холбогдох мэдээллээр хангаж ажиллаа. | 40 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.64. “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого”-ын 3.1.2-т заасан иргэд бичил уурхайн салбарт хууль ёсны бүтцээр хоршиж ажиллах чиглэлийг хэрэгжүүлэн холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно. | 1 | “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ыг шинэчлэн боловсруулах | 2016-2017 | УУХҮЯ | | -<br>Журмыг батлуулан хэрэгжүүлэх | Сайдын 2017 оны А/15 тоот тушаалаар "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, журмыг төслийг шинэчлэн боловсруулж, 2017 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, 2017 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 151 дүгээр тогтоолоор "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ыг шинэчлэн баталсан. | 100 |
| | 2 | Хууль бусаар ашигт малтмал олборлогчдыг нэгдсэн зохион байгуулалтад оруулах ажлыг зохион байгуулах | 2016-2020 | УУХҮЯ | | -<br>Нэгдсэн зохион байгуулалтад оруулах судалгаа хийх | "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-аар хууль бусаар ашигт малтмал олборлогчдыг хуулийн хүрээнд ажиллах нөхцлийг бүрдүүлж өгсөн. | 70 |
| 2.65. Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлт боловсруулж, салбар хоорондын уялдааг сайжруулна. | 1 | Уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах | 2017 | УУХҮЯ | | -<br>Төлөвлөлтийн баримт бичиг боловсруулж дуусгах | ТНБД-ийн 2017.10.09-ний өдрийн А/134 дугаар тушаалаар "Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийн баримт бичиг"-ийн төслийг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн хүрээнд Сангийн яам, Эрчим хүчний яам, Зам, тээврийн хөгжлийн яам, холбогдох агентлагаас төлөөллийг оруулж, шаардлагатай мэдээллийг авч нэгтгэн судалгааны тайланг боловсруулж дуусгаад байна. | 40 |
| | 2 | Уул уурхайн дэд бүтцийн хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд салбар хоорондын уялдаа холбоог хангах | 2016-2020 | УУХҮЯ | | -<br>Дэд бүтцийн хөгжлийн талаар хамтран ажиллах механизм бүрдүүлэх | Судлагааны тайланд үндэслэн хөтөлбөр боловсруулах ажлыг 2018 оны 1 дүгээр улиралд багтаан дуусгахаар ажиллаж байна. | /-/ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.66. Уул уурхайн судалгааны нэгж байгуулж, эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулалтын таатай орчинг бий болгоно. | 1 | Уул уурхайн судалгааны нэгж байгуулах талаар санал боловсруулах | 2017 | УУХҮЯ | | -<br>Санал боловсруулах | Уул уурхайн судалгааны нэгж байгуулах талаар санал боловсруулахаархолбогдох мэдээллийг цуглуулан боловсруулж санал, дүгнэлт боловсруулсан. | 40 |
| | 2 | Уул уурхайн судалгааны нэгж байгуулах саналыг холбогдох байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлэх | 2017 | УУХҮЯ | | -<br>Нэгж байгуулагдах асуудлыг шийдвэрлүүл эх | Уул уурхайн судалгааны нэгж байгуулах талаар санал боловсруулахаархолбогдох мэдээллийг цуглуулан боловсруулж санал, дүгнэлт боловсруулсан. | 40 |
| 2.67. Хоёрдогч ашигт малтмал ашиглах эрх зүйн орчинг бий болгож, уурхайн нөхөн сэргээлт, хаалтыг олон улсын жишигт хүргэнэ. | 1 | Тухайн үйлдвэрийн технологиор ашиглах боломжгүй овоолго, хаягдлын аж ахуйг эргүүлэн ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх | 2017 | УУХҮЯ | | -<br>Эрх зүйн орчин бүрдэх | Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн УИХ-аар хэлэлцэн батлагдсантай холбоотойгоор “Үсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагааны журам” болон “Үсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам”-ын төслийг боловсруулж, Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, “Журам батлах тухай” Засгийн газрын 2017 оны 61 дүгээр тогтоолоор батлуулсан ба Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/93 дугаар тушаалаар журмын хэрэгжилтийг зохион байгуулах Ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна. | 100 |
| | 2 | Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн журмыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж мөрдүүлэх | 2017-2018 | УУХҮЯ | | -<br>Журмын төсөл боловсруулах | “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам”-ын төслийг боловсруулах Дэд ажлын хэсгийг УУХҮЯ, БОАЖЯ, АМГТГ болон судлаачдын бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж, Ажлын хэсгийн хурлыг 3 удаа зохион байгуулж, журмын төслийн талаар санал солилцсон. Журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх чиглэлээр холбогдох судалгааг хийж, вэб сайтад төслийг байршуулан олон нийтийн саналыг авч байна. Журмын төсөлд санал авахаар БОАЖЯ-нд 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдөр 01/1166 албан тоотоор хүргүүлсэн ба БОАЖЯ-наас SESMIM төслийн хийж байгаа судалгааны дүгнэлт, санал гараагүй мөн "Уул уурхайн тухай" хууль батлах хүртэл энэхүү журмыг хойшлуулах саналыг ирүүлсэн бөгөөд SESMIMтөслийн хүрээнд хийгдэж байгаа хаалтын | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | талаарх судлагааны тайланг хэлэлцэгдэхийгхүлээж байна. | |
| 2.68. “Алт-2” хөтөлбөрийг хэрэгжүүлэх эд шаардагдах санхүүжилтийг Монголбанктай хамтран шийдвэрлэнэ. | 1 | “Алт-2” хөтөлбөрийн санхүүжилтийн тооцоог гаргах | 2017 | УУХҮЯ | | -<br>Судалгаа хийж, тооцоог гаргах | Алтны санхүүжилтийн асуудлаар Сангийн яам, Монголбанкны салбар зөвлөлийн холбогдох хүмүүс, алт олборлогч томоохон 25 аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулсан уулзалтыг УУХҮЯ дээр зохион байгуулсан. Санхүүжилт шаардлагатай алтны 130 төслийн судалгааг гаргаж Хөгжлийн банкинд хүргүүлсэн. | 100 |
| | 2 | Санхүүжилтийн тооцоог Монголбанкинд хүргүүлж шийдвэрлүүлэх | 2016-2017 | Монгол банк | | Гадаад зээл 250,000.0<br>Санхүүжилт шийдвэрлэгдэх | Алт-2 хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэх аж ахуйн нэгжүүдийн судалгаа, зээлийн хэмжээг тооцоолон Монголбанкинд хүргүүлсэн.Санхүүжилтийн асуудлыг Сангийн яам болон Хөгжлийн банктай хамтран шийдвэрлсэн.Үүний үр дүнд Хөгжлийн банк зээллэг хүссэн 25 аж ахуйн нэгжийг судалж, материалын бүрдэл хангасан 8 аж ахуйн нэгжид 24,8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсон бөгөөд 2017 оны 12 сарын 31-ний байдлаар нийт 20,01 тн алт Монголбанкинд тушаасан байна. | 100 |
| 2.69. Алтны олборлолтыг нэмэгдүүлж, бичил уурхай эрхлэгчдийн олборлосон алтыг худалдан авах эрх зүйн орчинг бүрдүүлнэ. | 1 | "Алт-2” хөтөлбөрийг боловсруулан батлуулах | 2016-2017 | УУХҮЯ | | -<br>Хөтөлбөр батлагдах | СС, УУХҮС, БОАЖС, Монголбанкны ерөнхийлөгчийн 2016 оны 403, А/68, А/136, А-339 тоот хамтарсан тушаалаар Ажлын хэсэг байгуулж “Алт-2” үндэсний хөтөлбөрийн төслийг эцэслэн боловсруулан Засгийн газрын 2017 оны 1-р сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 20-р тогтоолоор батлуулсан. | 100 |
| | 2 | Хөтөлбөр батлагдсантай холбогдуулан холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах | 2017-2018 | УУХҮЯ | | -<br>Хууль, эрх зүйн орчныг боловронгуй болгох чиглэлээр судалгаа хийх | “Алт-2” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Ерөнхий сайдын 2017 оны 17-р захирамжаар хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, уялдуулан зохицуулах, тайлагнах чиг үүрэг бүхий байнгын ажиллагаатай орон тооны бус Зөвлөл байгуулсан. Зөвлөлийн бүрэлдэхүүнд 4 дэд салбар, холбогдох хууль эрх орчинг боловсронгуй болгохоор төлөвлөгөө боловсруулан батлуулсан. Төлөвлөгөөнд тусгагдсан эрх зүйн баримт бичгүүдэд оруулах нэмэлт, өөрчлөлтүүдийн судалгааг хийсэн. | 70 |
| | 3 | Алтны геологийн судалгаа, эрэл- | 2017-2018 | УУХҮЯ | | Улсын төсөв 2,000.0 | “Алт-2” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу Монгол орны төв, зүүн бүсийн алтны | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | үнэлгээ, хайгуулын ажлыг хэмжээг өсгөн нөөцийг тогтвортой нэмэгдүүлэх | | | Батлагдсан - 1740.0 Гүйцэтгэл – 1528,0 Санхүүжилт - 1528,0 | Алтны хэтийн төлвийг үнэлэх чиглэлээр эрэл-үнэлгээний ажлыг эхлүүлэх | хэтийн төлвийг үнэлэх эрэл-үнэлгээний сэдэвчилсэн судалгааны ажлын геологийн даалгаврыг боловсруулан ТНБД-аар тушаалаар баталсан. Төслийн 2017 оны төсөв, төлөвлөгөөг сайдын А/96 дугаар тушаалаар батална гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан ажлыг эхлүүлсэн. Төслийн 2017 оны хээрийн судалгааны ажлын анхдагч материалыг хүлээн авсан.Алтны шороон ордын 25, үндсэн ордын 4 хайгуулын ажлын үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн улсын нөөцийн санг 6226.81кг нөөцөөр нэмэгдүүлсэн. | |
| | 4 | Сорьцын хяналтын албаны чадавхийг бэхжүүлж, техник технологийг шинэчлэх | 2016-2017 | СЯ | | Улсын төсөв 1,200.0<br>Хүчин чадлыг нэмэгдүүлж, техник технологийг шинэчлэх | Швейцарийн Хөгжлийн Агентлаг /ШХА/-ийн "Тогтвортой бичил уурхай" төслөөс 2016 онд 6 кг хүртэлх жинтэй алт хайлах зуух 1 ширхэгийг дагалдах тоног төхөөрөмжийн хамт Сорьцын хяналтын газарт худалдан авч өгсөн бөгөөд одоогийн байдлаар гааль дээр хүлээгдэж байна. Нийтдээ 40,0 сая орчим төгрөг зарцуулсан байна. Төслийн зүгээс 2017 онд аналитик жин 2 ширхэгийг, үнэт металлын сорьц тогтоох XRF машин 1 ширхэгийг нийт 80.0 сая орчим төгрөгөөр авч өгсөн байна. | 100 |
| | 5 | Алтыг боловсруулж нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэрийг байгуулах | 2017 | СЯ | | Гадаад зээл 2,000.0 | Монголбанкны Ерөнхийлөгч болон Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2017 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А/62, А/98 хамтарсан тушаалаар Алт цэвэршүүлэх үндэсний үйлдвэр барьж байгуулах талаар судалгаа хийж санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд Монголбанк, Швейцарь улсын ARGOR-HERAEUS S.A. компанийн төлөөлөлтэй Алт цэвэршүүлэх үйлдвэрийн суурь судалгааг хийлгэх асуудлаар уулзалт зохион байгуулж, тус судалгааны тайланг Монголбанкны захиалгаар ARGOR-HERAEUS S.A.компани боловсруулахаар тохиролцож, эдгээр байгууллагуудын хооронд хамтран ажиллах гэрээ хийгдсэн байна. | 40 |
| | | | | | | Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх | | |
| | 6 | Ашиглалтад оруулахад бэлэн болсон алтны уурхай, баяжуулах үйлдвэрийг байнгын | 2016-2020 | УУХҮЯ | | -<br>Алтны олборлолтын хэмжээ нэмэгдэх | 2016 онд 15 алтны уурхай, 2017 онд 14 уурхайд комисс ажиллан ашиглалтанд хүлээн аваад байна. | 40 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ашиглалтад оруулахад дэмжлэг үзүүлэх | | | | | | |
| | 7 | Бичил уурхай төвлөрсөн нутаг дэвсгэрт алтны худалдааны нэг цэгийн үйлчилгээ байгуулах талаар судалж хэрэгжүүлэх | 2016-2019 | УУХҮЯ | | -<br>Холбогдох байгууллагуудтай хамтран нэг цэгийн үйлчилгээ байгуулах талаар судлагаа хийх | Бичил уурхай төвлөрсөн нутаг дэвсгэрт алтны худалдааны нэг цэгийн үйлчилгээ байгуулах талаар судалгаа хийгдэж байна. Холбогдох байгууллагатай хамтарсан ажлын хэсэг байгуулахаар ажиллаж байна. | 40 |
| | 8 | “Алт олборлож угаах, хүлээлцэх, хадгалах, хамгаалах, тээвэрлэх, улсад тушаах үлгэрчилсэн дүрэм”-ийг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх | 2017 | УУХҮЯ | | -<br>Журмын төслийг боловсруулж батлуулах | "Алт агуулсан хүдэр, элс олборлон баяжуулах, хамгаалах, хадгалах, тээвэрлэх болон худалдахтай холбогдсон журам"-ын төслийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулж, хуульд заасны дагуу Нөлөөллийн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэж Хуулийн хэлтэст хүргүүлэн хянуулсан. Журмын төслийг яамны веб сайтад байршуулан олон нийтийн санал, зөвлөмжийг авч, улмаар Сангийн яам, Стандартчлал, хэмжил зүйн газар, Цагдаагийн ерөнхий газар, Монголын алт үйлдвэрлэгчдийн холбооноос санал авч тусгасан. АМГТГ-тай хамтран алтны чиглэлээр тусгай зөвшөөрөл эзэмшигч зарим аж ахуйн нэгжүүдтэй уулзалт зохион байгуулж, уулзалтын үеэр алтны салбарт тулгамдаад байгаа асуудал, тэдгээрийг шийдвэрлэх нөхцөл боломжийн талаар санал солилцон шинээр боловсруулсан журмын төслийг танилцуулан хэлэлцүүлэг хийж тэдгээрээс гарсан саналыг журмын төсөлд тусгасан. Мөн Журам батлах тухай эрх зүйн үндэслэл байхгүй учир Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тус журмыг Геологи, уул уурхайн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батлах зохицуулалтыг тусгасан. | 70 |
| 2.70. Газрын тосны | 1 | Газрын тос боловсруулах | 2016-2017 | УУХҮЯ | | - | Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 20-ний өдрийн “Төрийн өмчит компани” байгуулах тухай 92 дугаар | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн , газрын тос боловсруула х үйлдвэр байгуулна. | | үйлдвэр барих төслийн нэгж байгуулах, үйлдвэрийн дэд бүтцийн нарийвчилсан судалгаа, үйлдвэр болон дамжуулах хоолойн газрын асуудлыг шийдвэрлэх | | | | Төслийн нэгж байгуулагдах, үйлдвэрийн дэд бүтцийн судалгаа хийгдэх | тогтоол батлагдаж “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийг хэрэгжүүлэх 100 хувь төрийн өмчит компани байгуулахаар шийдвэрлэсэн. Уг тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн “Хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулах тухай” 108 дугаар тогтоол батлагдаж “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах үүрэг бүхий “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна. | |
| | 2 | Төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн хэмжээний талаар санал боловсруулах, холбогдох шийдвэрийг гаргуулах, төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах бэлтгэлийг хангах | 2017 | УУХҮЯ | | Улсын төсөв 516.0<br>Санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн талаар холбогдох шийдвэрийг гаргуулах | "Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг шийдвэрлэх ажлын хүрээнд БНЭУ-аас Монгол Улсын Засгийн газарт олгохоор шийдвэрлэсэн 1 тэрбум ам.долларын хөнгөлөлттэй зээлийн зориулалтыг “......... дэд бүтэц, хөдөө аж ахуйн болон бусад төсөл” байсныг “...аж үйлдвэр, дэд бүтэц, хөдөө аж ахуйн болон бусад төсөл” болгон нэмэлт өөрчлөлт оруулж “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийг санхүүжүүлэхээр шийдвэрлэж Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн “Зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн” тухай 59 дугаар тогтоолыг баталсан.<br>Хоёр улсын Зээлийн ерөнхий хэлэлцээрийн зориулалтад нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг УИХ-ын Эдийн засгийн, Төсвийн, Аюулгүй байдлын Байнгын хороодоорхэлэлцүүлэн дэмжигдэж зээлийн ерөнхий хэлэлцээр батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их хуралд өргөн барьж 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцэн соёрхон баталсан. | 100 |
| | 3 | Газрын тос боловсруулах үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ, барилгын зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэх | 2017 | УУХҮЯ | | Нарийвчилсан ТЭЗҮ, барилгын ажлын зураг төсөл хийгдэх | УУХҮЯ-ны ТНБД-ын 2017 оны А/16 тоот тушаалаар “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах зөвлөх компанийг сонгон шалгаруулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулсан. БНЭУ-аас олгох хөнгөлөлттэй зээлийн хүрээнд “Газрын тос боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг боловсруулах ажлыг эхлүүлж олон улсын нээлттэй тендерийг 2017 оны 02 дугаар сараас 08 дугаар сарын хооронд БНЭУ-ын Эксим банктай хамтран зохион байгуулж БНЭУ-ын “Инженерс Индиа Лимитед” компани зөвлөхөөр шалгарч УУХҮЯ болон “Монгол газрын тос | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсруулах үйлдвэр” ТӨХХК-тай Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гурвалсан гэрээг 2017 оны 08 дугаар сарын 09-ний өдөр байгуулж, ТЭЗҮ-ийн эхлэлийн тайланг /Inseption report/ 2017 оны 11 дүгээр сарын 12-ний өдөр ирүүлээд байна. | |
| | 4 | Барилгын ажлыг гүйцэтгэж, үйлдвэрийг хүлээн авч ашиглалтад оруулах | 2017-2020 | УУХҮЯ | | Гадаад зээл 2,400,000.0<br>Үйлдвэр барих ажил эхлэх | Хугацаа болоогүй. | /-/ |
| 2.71. Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг дэмжиж ажиллана. | 1 | Зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчийг сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах | 2016-2017 | УУХҮЯ | | -<br>Хуулийн этгээдийг сонгон шалгаруулах | УУХҮ-ийн Сайдын 2016 оны А/71 тоот тушаалаар “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр”-ийн төслийн нэгжийн захирал томилогдсон. 2017 оны 01 дүгээр сард төслийн нэгжийн бүтэц, үйл ажиллагааны төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн дарга баталсан. 2017 оны Төсвийн тодотголоор үйл ажиллагааны төсөв нь батлагдан хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эрчимжүүлэх тухай" 88 дугаар тогтоолоор үйлдвэрийн нийт хувьцааны 10-аас доошгүй хувийг хөрөнгө оруулалтын зардал гаргахгүйгээр төр үнэ төлбөргүйгээр эзэмшихээр шийдвэрлэсэн. Төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх боломжит хувилбаруудыг судалж байгаа ба энэ хүрээнд дотоодын хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендер шалгаруулалтыг зарлаж “Таван Лекс” ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Мөн төсөлд хөрөнгө оруулах, технологи нэвтрүүлэх сонирхолтой гадаад, дотоодын компаниудтай уулзалт хийж байна. | 70 |
| | 2 | Үйлдвэрийн нарийвчилсан зураг төслийн ажлыг хийх | 2016-2017 | УУХҮЯ | | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 4,400.0<br>Үйлдвэрийн зураг, төсөл хийгдэх | Үйлдвэрийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын А/109 тоот тушаалаар "Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр" барих талбайн байршлыг төмөр зам, ус, эрчим хүчний хангамж болон бусад дэд бүтцийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлттэй уялдуулан тодорхойлох зорилгоор “Оюутолгой” ХХК-ын удирдлага болон орон нутгийн төр, захиргааны байгууллагуудтай Өмнөговь аймагт уулзалт зохион байгуулсан.ЗТХЯ, “Оюутолгой” ХХК болон “Монголын Төмөр Зам” ТӨХК-тай үйлдвэрийн байршилийн асуудлаар хэлэлцэж газрыг урьдчилсан байдлаар товлосон. Төсөлд шаардлагатай 150га газрыг Өмнөговь аймгийн Ханбогд сумын газар зохион | 40 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах асуудлыг Ханбогд сумын 2017 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанаар хэлэлцүүлж, 04/05 тоот тогтоолоор тус сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулсан.<br>Мөн Засгийн газрын 88 дугаар тогтоолын тэмдэглэлд Өмнийн говьд шинээр баригдах Уул уурхай, аж үйлдвэрүүдийн усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх арга замын боломжит хувилбарыг 2017 онд багтаан зохих журмын дагуу Засгийн газарт оруулахыг даалгасан. Уг тэмдэглэлийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд БОАЖЯ-тай хамтран “Говийн бүсийн ус хангамжийн асуудлыг шийдвэрлэх арга зам” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийг үндэслэн Засгийн газрын 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж “Хэрлэн гол дээр урсацын тохируулга хийх төслийн тухай” 232 дугаар тогтоолыг батлуулсан. | |
| | 3 | Үйлдвэр байгуулж, ашиглалтад оруулах | 2017-2020 | УУХҮЯ | | Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт 1,756,480.0<br>Үйлдвэр барих ажил эхлэх | Хугацаа болоогүй. | /-/ |
| 2.72. Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолбор байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ. | 1 | Дархан-Сэлэнгийн бүсэд байгуулах хар төмөрлөгийн цогцолбор төслийн ТЭЗҮ болон БОННҮ-г боловсруулах ажлыг гүйцэтгэж дуусгах | 2016-2017 | УУХҮЯ | | ТЭЗҮ болон БОННҮ-г хүлээн авах | “Дархан-Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборыг дэд бүтцийн хамт байгуулах төсөл”-ийн ТЭЗҮ-ийн тайланг 2017 оны 9 дүгээр сард хүлээж авсан ба БОННҮ-ний тайланг 2018 оны 1 дүгээр улиралд хүлээж авахаар ажиллаж байна. | 70 |
| | 2 | Давтах аргаар ган бөмбөлөг үйлдвэрлэх цехийг ашиглалтад оруулах | 2016-2017 | УУХҮЯ | | Үйлдвэр ашиглалтад орох | “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК нь давтах аргын ган бөмбөлгийн үйлдвэрийг 2017 оны 01 сарын 28-нд ашиглалтанд оруулсан. Үйлдвэрийн нээлтийн ажиллагаанд яам, агентлагийн төлөөлөл оролцов. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 3 | Төмөртэйн уурхайд хуурай болон нойтон соронзон баяжуулах үйлдвэр байгуулах | 2017-2018 | УУХҮЯ | | Үйлдвэрийн барилгын ажил явагдах | Төмөртэйн уурхайд хуурай болон нойтон соронзон баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн барилгын ажлыг эхлүүлэх төлөвлөгөө “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-ийн 2017 оны төлөвлөгөөнд тусгагдсан ба тоног төхөөрөмжийн үнийн судалгаа, хөрөнгө оруулалтын арга замуудыг судалж байна. | 40 |
| | 6 | Гангийн үйлдвэрлэлийн бизнесийн таатай орчныг бүрдүүлж, төмөрлөгийн үйлдвэрүүдийн ашиглалтыг сайжруулах, импортын хэмжээг бууруулах | 2017-2020 | БХБЯ | | Төр, хувийн хэвшлийн түншлэл 200,000.0 | Төмрийн хүдэр, баяжмал экспортлох төмөр замын тээврийн тарифыг уян хатан болгох асуудлаар “Улаанбаатар төмөр зам” ХНН, болон Төмөрлөг үйлдвэрлэгчдийн холбооны төлөөллийг оролцуулан УУХҮ-ийн Сайдтай уулзалт зохион байгуулав. | 40 |
| | | | | | | Төмөрлөгийн үйлдвэрлэлийг дэмжиж, гангийн үйлдвэрлэлийн бизнесийн таатай орчныг бүрдүүлэх чиглэлээр зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх | | |
| 2.73. Нүүрс угаах, гүн боловсруулах үйлдвэр болон нүүрсний нийлэг хийн үйлдвэр байгуулахыг бодлогоор дэмжинэ. | 1 | Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр байгуулах төслийн нэгж байгуулах | 2016-2017 | УУХҮЯ | | Төслийн нэгж байгуулагдах, холбогдох судалгаа хийгдэх | Засгийн газраас 2016 онд баталсан 107 дугаар тогтоолоор “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр” барих төслийг хэрэгжүүлэх нэгжийг байгуулахаар шийдвэрлэж Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/43 дугаар тушаалаар Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн төслийн нэгжийг байгуулан ажиллаж байгаа ба Төслийн нэгжийн бүтэц, үйл ажиллагааны төлөвлөгөөг Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. 2017 оны Төсвийн тодотголоор үйл ажиллагааны төсөв нь батлагдан ажиллаж байна. | 100 |
| | 2 | Дэлхийн банкны санхүүжилтээр боловсруулагдсан нүүрснээс | | УУХҮЯ | | Урьдчилсан ТЭЗҮ-ийг хүлээн авах | “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр”-ийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр холбогдох мэргэжлийн хүмүүсээр хэлэлцүүлэн хүлээн авсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн урьдчилсан ТЭЗҮ-ийг хүлээж авах | | | | | | |
| | 3 | Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэрийн нарийвчилсан ТЭЗҮ болон БОННҮ-г Хүнд үйлдвэрийн шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэх | 2017 | УУХҮЯ | | Улсын төсөв 318.0<br>Нарийвчилсан ТЭЗҮ, БОННҮ-ний тайланг хүлээж авах | “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр”-ийн нарийвчилсан ТЭЗҮ-ийг 2017 оны 05 сарын 6-ны өдөр яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж хүлээн авсан. Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр байгуулах төслийн нэгжийн байгаль орчны үнэлгээг гүйцэтгэгч“Green Trend” ХХК нь эхний урьдчилсан тайлангаа “MINIS” төсөлд хянуулахаар өгсөн. Тус тайланг Минис төсөл баталсан тохиолдолд БОАЖЯ-ны мэргэжлийн зөвлөл хэлэлцэнэ. | 100 |
| | 4 | Төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн хэмжээний талаар санал боловсруулах, холбогдох шийдвэрийг гаргуулах, төсөл хэрэгжүүлэх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах бэлтгэлийг хангах | | УУХҮЯ | | Санхүүжилт, хөрөнгө оруулалт, хувь эзэмшлийн талаар холбогдох шийдвэрийг гаргуулах | Ерөнхий сайдын 2016 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 113 дугаар захирамжаар “Нүүрснээс нийлэг байгалийн хий үйлдвэрлэх үйлдвэр” барьж байгуулах төслийн хөрөнгө оруулагчтай хамтран ажиллах талаар хэлэлцээ хийж, санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. УУХҮЯ, төслийн нэгжийн төлөөлөл Төв аймгийн Баяндэлгэр сумын орон нутгийн удирдлага, холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт хийж, төслийн БОНННҮ-ний бүрэлдэхүүн хэсэг болох “олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Төслийг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх боломжит хувилбаруудыг судалж, дотоодын хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх нээлттэй тендер сонгон шалгаруулалтыг зарлаж, тендерт шалгарсан “БЕЗ Партнерс” ХХК-тай гэрээ байгуулан ажиллаж байна. Хөрөнгө оруулалт хийх чиглэлээр холбогдох саналыг боловсруулан, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. | 40 |
| 2.74. Шингэрүүлсэ | 1 | Улаанбаатар хотод жилд | 2016-2019 | УУХҮЯ | | - | Төсөл хэрэгжүүлэгч "Интер стандарт нефть" ХХК нь ХБНГУ-ын "EDL Anlagenbau" компаниар үйлдвэрийн | 40 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| н түлш, шатах тослох материалын үйлдвэр байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ. | | 15,000 тн тос, тосолгооны материал үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр байгуулахыг дэмжих | | | | Үйлдвэр барих ажил эхлэх | ТЭЗҮ-г гүйцэтгүүлж дуусан 2016 оны 04 дүгээр сард Аж үйлдвэрийн яамны /хуучнаар/ ШУТЗ-өөр үйлдвэрийн ТЭЗҮ-г хэлэлцүүлэн дэмжүүлсэн. Төслийн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 43 сая ам.доллар бөгөөд үнээс "Интер стандарт нефть" ХХК нь өөрийн хөрөнгөөр төслийн нийт хөрөнгө оруулалтын 20%-г, 60%-г Германы "HypoVereinsbank"-ны зээлийн эх үүсвэрээр үлдсэн 20%-ийн МУ-ын Хөгжлийн банкны хөнгөлттэй зээлийн эх үүсвэрээр тус тус санхүүжүүлэхээр тохиролцож шаардлагатай бичиг баримтыг хүргүүлээд байна. | |
| 2.75. Метал хийц, угсралтын үйлдвэрийг хөгжүүлнэ. | 1 | Автомашин, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, машин механизм угсрах, автомашины эд анги үйлдвэрлэх үйлдвэр, технологийн парк байгуулахыг дэмжих | 2017-2020 | УУХҮЯ | | -<br>Үйлдвэр, технологийн парк байгуулах судалгааны ажлууд хийгдэх | Автомашин, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж,машин механизм угсрах, автомашины эд ангиүйлдвэрлэх чиглэлээр Япон, Герман, БНХАУ, ОХУ-ын туршлагыг судалж, Япон Улсын Тоёота компанийн автомашины үйлдвэрлэлийн системийн талаар төслийн нэгжийн ажилтан газар дээр нь очиж танилцсан. Мөн Монгол улсад энэ чиглэлийн үйлдвэрлэл эрхэлж байгаа үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай танилцаж мэдээллүүдийг нэгтгэн, үйлдвэрлэл, технологийн парк байгуулах боломж нөхцөлийн талаар судалгааг зохион байгуулсан. | 40 |
| | 2 | Ачааны автомашин, нийтийн тээвэр, хөдөө, аж ахуйн машин, механизмыг угсрах үйлдвэрлэлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох | 2016-2017 | УУХҮЯ | | Эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Автомашин, нийтийн тээвэр, хөдөө, аж ахуйн машин, механизмыг угсрахад зориулагдсан тоног төхөөрөмжийг импортлоход НӨАТ, Гаалийн татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл боловсруулсан бөгөөд Сангийн Яамнаас уг асуудлыг Засгийн газарт болон УИХ-д оруулж хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. | 100 |
| 2.92. Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн ус болон хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах | 2 | Хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах чиглэлээр судалгаа хийх | 2016-2018 | БХБЯ | | Судалгаа хийж, төсөл боловсруулах | ШУТИС-ын дэргэдэх Усны судалгааны төвөөс Хөрсний усыг үйлдвэрийн хэрэгцээнд ашиглах, энэ чиглэлээр судалгаа хийхэд шаардагдах төсөв, хөрсний усыг ашиглах төслийн саналыг үндсэн хэрэгжүүлэгч БХБЯ-нд ирүүлсэн ба асуудлыг судалж байна. | /-/ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| боломжийг бүрдүүлнэ. | | | | | | | | |
| 2.106. Метан хийг ашиглах боломжит нөөцийг бүрдүүлэх судалгааг эрчимжүүлэх, хийн хангамжийг хөгжүүлэх эрх зүй, дэд бүтцийн орчныг бүрдүүлэх, нүүрснээс хийн цэвэр түлш гарган авах үйлдвэр барих төслийг эхлүүлнэ. | 1 | Метан хийн нөөцийг бүрдүүлэх болон салбарын хөгжлийг дэмжсэн бүтэц зохион байгуулалтыг бий болгох | 2016-2017 | ЭХЯ | | Холбогдох шийдвэрүүд гарах | Метан хийн хангамжийн салбарын зохион байгуулалтын бүтцийг MNS 6659-2017 стандартаар тодорхойлон батлуулж, эрх зүйн орчинг бүрдүүлээд байна. | /-/ |
| **Тэргүүлэх зорилт №3.2.2. Шинжлэх ухааны удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгож, үр дүнд суурилсан санхүүжилтийн системийг нэвтрүүлж, мэдлэгт суурилсан инноваци, технологи, үйлдвэрлэлийг хөгжүүлж, шинжлэх ухааны үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | |
| 3.2.33. Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт олон улсын жишигт нийцсэн барилга, байгууламж, лабораторын орчин нөхцөл | 11 | Шинжлэх ухаан, танин мэдэхүйн мэдээллийн төв байгуулах барилга, байгууламжийн дотоод зураг төсөл, үзүүлэн бэлтгэх, макет, үзвэрүүдийг хийх, тохижолт болон бусад арга хэмжээг | 2017 | ЦЭКАА | | Байгууламжийн дотоод зураг төсөл, үзүүлэнг бэлтгэх | Үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаас хийгдсэн ажил байхгүй байна. | /-/ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| бүхий дэд бүтцийг бий болгохыг дэмжинэ. | | зохион байгуулах | | | | | | |
| **Тэргүүлэх зорилт №4.1. Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх, байгалийн нөөц баялгийг хамгаалах, хомсдлоос сэргийлэх, зохистой ашиглах, нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэн, байгаль орчинд нийцтэй, хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжлийн үндэс болгоно. Аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг бүс нутгийн хэмжээнд дээшлүүлж, эрх зүйн таатай орчинг бүрдүүлж, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | | |
| 4.1.3. Байгаль орчны багц хуулийг хэрэгжүүлэх цогц арга хэмжээ авч, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй үйлдвэрлэл, үйлчилгээ болон байгалийн нөөцийн хууль бус ашиглалтад тавих хяналтыг сайжруулна. | 1 | Байгаль орчны үнэлгээ, аудитаар дамжуулан ашиглагч нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх | 2016-2020 | БОАЖЯ | | 200-250 төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан баталж, хэрэгжилтийг хангуулах | Үндсэн хэрэгжүүлэгч БОАЖЯ-наас хамтран ажиллах санал ирүүлээгүй байна. | /-/ |
| 4.1.6. Хот, суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлын зохистой | 1 | Цэвэр агаар санг байгуулж, агаарын бохирдлыг бууруулах үр дүнтэй арга хэмжээ авах | 2016-2020 | БОАЖЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ-ууд | | Агаарын чанарыг сайжруулах бүсийг цэвэр түлшээр хангах, эрчим хүч, дулааны алдагдлыг бууруулах, өндөр үр ашигтай халаалтын технологи | Улаанбаатар хот болон томоохон суурин газруудад 2017 оноос шатахууны чанарыг Евро-5 стандартад шилжүүлэхээр төлөвлөсөн ажлын хүрээнд автобензин, дизель түлшний Евро-5 стандартын жишигт нийцсэн Үндэсний стандартын төсөл боловсруулан Стандартчиллын Үндэсний хорооны 2017 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Мөн “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-т холбогдох зорилт, арга хэмжээг тусгуулсан. Евро-5 стандартын шатахууныг хэрэглээнд өргөнөөр нэвтрүүлэхэд | 40 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| менежментийг хэрэгжүүлнэ. | | | | | | нэвтрүүлэхийг дэмжих | борлуулалтын үнийн асуудлыг ард иргэдэд санхүүгийн хүндрэл багатайгаар шийдвэрлэх шаардлага үүсээд байгаа бөгөөд уг асуудлыг “Газрын тосны бүтээгдэхүүний хангамж, үнийг тогтворжуулах асуудлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын хамтарсан зөвлөл”-ийн 2017 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн Зургаадугаар хуралдаанаар хэлэлцүүлсэн. Зөвлөлөөс өгсөн зөвлөмж болон дээрх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд Евро-5 стандартад нийцсэн автобензин, дизель түлшний хэрэглээг нэмэгдүүлэх, чанарын шаардлага хангахгүй байгаа автобензин, дизель түлшний импорт, борлуулалт, үйлдвэрлэлийг хязгаарлах, онцгой албан татварыг чанар, стандарттай уялдуулан тогтоох хууль, эрхзүйн орчин бүрдүүлэх зорилгоор Онцгой албан татварын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, танилцуулга, үзэл баримтлалыг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлүүлэхээр 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 01/2756 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. | |
| 4.2.3. Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, хаягдал бохир усыг цэвэрлэн дахин ашиглах технологи нэвтрүүлэхийг дэмжинэ. | 2 | Ус ашиглалтыг бүрэн тоолууржуулж, хаягдал бохир усыг цэвэрлэж, дахин ашиглалтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах | 2017-2020 | БОАЖЯ | | Усны тоолууртай ус ашиглагчийн тоо болон ус эргүүлэн ашиглалт, дахин ашиглалтыг дэмжиж нэмэгдүүлэх | Үндсэн хэрэгжүүлэгч БОАЖЯ-наас хамтран ажиллах санал ирүүлээгүй байна. | /-/ |
| 4.2.6. Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах бодлого хэрэгжүүлж, уул уурхайн хайгуул, | 1 | Уул уурхайн улмаас эвдэрсэн газрын хохирлыг тооцох, нөхөн сэргээх эрх зүйн зохицуулалтыг бий болгох, нөхөн сэргээлт хийх | 2016-2020 | БОАЖЯ | | Уул уурхайн улмаас эвдэрсэн газрын хохирлыг тооцох, нөхөн сэргээх хуулийн төсөл боловсруулах | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын А/85 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нийт 21 аймагт бүсчилэн 10 чиглэлд орон нутагт томилолтоор ажиллаж, орон нутгийн удирдлага, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй уулзалт хийж, чиглэл хүргүүлсэн. | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| олборлолтод өртөж, эвдрэлд орсон газар нутгийг нөхөн сэргээнэ. | 3 | Аж ахуйн нэгж, мэргэжлийн байгууллагын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх, чадавхийг бэхжүүлэх замаар нөхөн сэргээлтийн ажлын чанар үр дүнг дээшлүүлэх, орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх | 2017-2020 | БОАЖЯ, МХЕГ | | Ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй ААН, газрын хэвлийн нөхөн сэргээлтийн мэргэжлийн байгууллага, нутгийн иргэдийн оролцоотойгоор 300-аас доошгүй га талбайд нөхөн сэргээлт хийх | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын А/85 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нийт 21 аймагт бүсчилэн 10 чиглэлд орон нутагт томилолтоор ажиллаж, орон нутгийн удирдлага, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй уулзалт хийж, чиглэл хүргүүлсэн. | 70 |
| | 4 | Уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах дэд хөтөлбөр хэрэгжүүлж, холбогдох стандартуудыг шинэчлэх, сургалт, судалгааны төв байгуулах | 2016-2020 | БОАЖЯ | | Уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах дэд хөтөлбөрийн төсөл боловсруулж, сургалт судалгааны төвийн барилгын ажлыг эхлүүлэх | Үндсэн хэрэгжүүлэгч БОАЖЯ болон БНСУ-ын Уул уурхайн Нөхөн Сэргээлтийн Корпораци (MIRECO) хамтранБНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй “Монгол улсад Уул уурхайн сөрөг нөлөөллийг бууруулах менежментийн чадавхийг бэхжүүлэх” төслийн Мастер төлөвлөгөө боловсруулах багт яамны төлөөлөл оролцож холбогдох санал өгч ажилласан. | 70 |
| | 5 | Орхон, Туул гол болон бусад голуудын хамгаалалтын бүсэд ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж буй ААН-ийг хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээ авах, хариуцлагатай уул уурхайн | 2016-2019 | БОАЖЯ | | Орхон, Туул болон бусад томоохон голуудыг бохирдуулж буй үйл ажиллагааг зохицуулж, хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт Ашигт малтмал, газрын тосны газрын төлөөлөл орж ажилласан бөгөөд шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажилласан. Ажлын хэсэг нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийг технологийн горимын дагуу үйл ажиллагаа явуулах талаар чиглэл, зөвлөмж өгч ажилласан бөгөөд энэ тухай саналыг ажлын хэсэгт хүргүүлсэн. | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | зарчмыг мөрдүүлж усны бохирдлыг бууруулах | | | | | | |
| | 6 | Баруун бүсэд дүйцүүлэн хамгааллын жишиг төсөл хэрэгжүүлэх | 2016-2019 | БОАЖЯ | | Баян-Айраг, Хотгор, Хөшөөтийн орд газрын биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгааллын хөтөлбөрийг боловсруулах | Үндсэн хэрэгжүүлэгч БОАЖЯ-наас Даян дэлхийн байгаль хамгаалах сан /GEF/ НҮБХХ-ийн буцалтгүй тусламжтайгаар нийт 1,289,863 ам.долларын санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа Монгол орны баруун бүсэд хөгжлийн сөрөг нөлөөлөл, газрын доройтлыг бууруулах үе шат, дүйцүүлэн хамгааллыг ландшафтын түвшний төлөвлөлт, менежментэд нэвтрүүлэх замаар уул уурхайгаас бэлчээрт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилготой "Монгол орны баруун бүс нутгийн газрын доройтол, хөгжлийн сөрөг нөлөөллийг бууруулах, дүйцүүлэн хамгааллыг нэвтрүүлэх" төслийн Удирдах хороонд яамны төлөөлөл ажиллаж байна. Удирдах хорооны 2 дугаар хуралдаанд оролцсон. Төслийн хагас жилийн тайлантай танилцаж, санал хүргүүлсэн. | 40 |
| **Хэрэгжилт /хувь/** | | | | | | | | **68.4** |

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР